

# Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011

*Судалгааны тайлан*



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011

---

Судалгааны тайлан

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Уг судалгаатай холбоотой аливаа асуулт, тодруулга байвал Нээлттэй Нийгэм Форум буюу [Dorjdari@forum.mn](mailto:Dorjdari@forum.mn) цахим шуудангийн хаягаар хандана уу.

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,  
Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

DDC  
339.5  
О-435

ISBN 978-99962-56-22-6

# Агуулга

1. ӨМНӨХ ҮГ .....	4
2. ТАНИЛЦУУЛГА .....	6
3. РЕЙТИНГ .....	8
4. ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА .....	10
4.1. Оноо I: Төсвийн мэдээллийн хүртээмжтэй байдал .....	10
4.2. Оноо II: Ил тод, нээлттэй байдлын эрх зүйн орчин ба бодит байдал .....	16
5. БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ.....	29
6. ХАВСРАЛТУУД.....	32
6.1. Арга зүй .....	32
6.2. Асуулга .....	37
6.3. Асуулгыг бөглөх заавар.....	71
6.4. Асуулгын хариултауд.....	89
6.5. Судлаачид .....	92

## ӨМНӨХ ҮГ

Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгаа нь Монгол Улсын аймгууд болон нийслэл хотын төр, захиргааны байгууллагын түвшинд төсвийн баримт бичгийн ил тод байдал, төсвийн явцад иргэд оролцох боломжийг хараат бус байр сууринаас үнэлэх анхны оролдлого юм. Уг төслийг Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачлагын санхүүгийн болоод арга зүйн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум, “Иргэд Төсвөө Хянана” иргэний нийгмийн сүлжээтэй хамтран хэрэгжүүлээ. Уг төсөл 2010 оны дөрөвдүгээр сараас 2011 оны тавдугаар сарын хооронд хэрэгжиж ирсэн ба энэ хугацаанд судалгааны аргачлалыг боловсруулах, туршиж сайжруулах, судалгаа явуулах, дүгнэх зэрэг шат дараатай ажлыг гүйцэтгэлээ.

Уг төслийн гол үр дүн нь 21 аймаг болон нийслэл Улаанбаатар хотын төсвийн баримт бичиг, үйл явцын ил тод, нээлттэй байдалд оноо өгч чансаагаар нь эрэмбэлсэн жагсаалт юм. Төсвийн мэдээллийн хүртээмжийг үнэлсэн хоёр хүснэгт болон хэд хэдэн хариултын сонголттойгоор тусгайлан боловсруулсан нийт 60 асуулгад авсан оноогоор энэхүү эрэмбэлсэн жагсаалтыг гаргасан. Мэдээллийг газар дээр нь цуглуулах ажлыг орон нутагт ирэх жилийн төсвөө хэлэлцэн баталдаг хугацаанд буюу 2010 оны 11-р сараас 2011 оны 3-р сар хүртэл нийт 5 сарын хугацаанд цуглуулсан болно.

Судалгааны дүнд гарч байгаа төсвийн ил тод, нээлттэй байдлын ерөнхий дүр зураг тун тааруухан байна. Нийт авч болох 100 онооноос орон нутгийн засаг захиргаад дунджаар ердөө 34.9 оноо л авч байгаа нь төсвийг ил, нээлттэй болгох ноцтой шаардлага байгааг илтгэнэ. Ялангуяа ил тод, нээлттэй байдлыг эрх зүйн талаас хангасан байдал ердөө 17.3 оноо авсан нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Төсвийн мэдээллийн иж бүрэн, ил тод байдал 35.1 оноо, төсвийн үйл явцын нээлттэй байдал 38.1 оноотой байгаа нь ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлэхэд цаашид хийх ажил их байгааг илтгэнэ.


Дундаж оноо ийнхүү доогуур байхын зэрэгцээ аймаг тус бүрийн авсан оноо нэлээд зөрүүтэй гарлаа. Сонирхолтой нь, аймгуудын авсан оноог тэдгээрийн хөгжлийн индекс, хүн ам, төвөөс алслагдсан байдал, уул уурхайн лицензийн тоо зэрэг олон үзүүлэлттэй харьцуулан хоорондын статистик хамаарлыг судлахад хүчтэй уялдаа холбоо тогтоогдоогүй нь төсвийн ил тод, нээлттэй байдал нь тухайн аймгийн удирдлагын арга барил, хандлагаас, өөрөөр хэлбэл хүний хүчин зүйлээс ихээхэн хамаарч байгааг илтгэнэ.

Монгол Улсад анх удаагаа хийгдсэн уг судалгааны дүн нь цаашид иргэдийн суурь эрх болох төр засгийнхаа хийж буй ажлын талаар мэдээлэл авах, шийдвэр гаргах үйл явцад оролцох явдлыг сайжруулахын төлөө олон нийтийн, тэрдундаа бодлого боловсруулагчдын дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэхэд чухал хувь нэмрээ оруулна гэдэгт эргэлзэхгүй байна. Төсвийн мэдээлэл ил болсноор иргэд орон нутгийн засаг захиргааны хөтөлбөр, төслүүдийн ач холбогдол, эрэмбэ

зэргийн талаар ойлголттой болж, иргэд өөрсдөө үнэлэлт дүгнэлт өгөх, хяналт тавих боломж бүрдэх юм. Нөгөө талаас орон нутгийн засаг захиргааны хувьд ч уг судалгааны аргачлал нь иргэдэд хэрэгтэй төсвийн мэдээллийг боловсруулж, хүртээмжтэй арга замаар нийтэд мэдээлдэг болоход туслахуйц арга зүйн удирдамж юм. Өнөөгийн мэдээллийн технологи үсрэнгүй хөгжиж байгаа, мөн орон нутагт ялангуяа уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотойгоор орлого эрс нэмэгдэж байгаа энэ цаг үед орон нутгийн засаг захиргааны үйл ажиллагаанд иргэдийн зүгээс анхаарал, хяналт тавих сонирхол, шаардлага нэмэгдэж байна. Түүнчлэн төв засгийн газрын зүгээс ч орон нутгийг дэмжих, төсвийн төвлөрлийг сааруулах оновчтой алхмуудын эрэлд байгаа. Тиймээс ч орон нутгийн засаг захиргаа төсвийн мэдээллийг илүү ил тод, нээлттэй болгосноор ард иргэдийнхээ итгэлийг хүлээгээд зогсохгүй төсвийн илүү эрх мэдлийг бүрэн хэрэгжүүлэх чадвараа төв засгийн газар, бодлого боловсруулагчдад дахин нотлох юм.

Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын тухай энэхүү судалгааг бодит байдалд гарч буй аливаа өөрчлөлт, ахиц дэвшлийг тодорхойлох үүднээс хоёр жилд нэг удаа давтан явуулж байхаар төлөвлөж байгаа болно.

Уг судалгаа нь олон байгууллага, хувь хүмүүсийн хамтын ажиллагааны үр дүн юм. Судалгааг Нээлттэй Нийгэм Форумас санаачлан, ерөнхийд нь зохион байгуулсан ба “Иргэд төсвөө хянаана” иргэний нийгмийн сүлжээ, түүний дотор ахлах судлаачаар ажилласан дээрх сүлжээний зохицуулагч, “Ил тод байдал” сангийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, ИРИМ судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал М.Ариунтунгалаг, Эмэгтэй удирдагч сангийн тэргүүн М.Болормаа, Зориг сангийн гүйцэтгэх захирал Б.Оюундарь нарт тусгайлан талархал илэрхийлж байна. Аймаг бүрт, мөн нийслэлд судалгааны асуулгыг гардан бөглөсөн, судалгааны мэдээлэл, баримт цуглуулах ажлыг гүйцэтгэсэн судлаачдад мөн талархал илэрхийлж байна. Эцэст нь тус судалгааны аргачлалыг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулж, санхүүжилтийг хангасан Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачлагад гүн талархалаа илэрхийлье.



П. Эрдэнэжаргал  
Нээлттэй Нийгэм Форумын  
Гүйцэтгэх захирал

# 2

## Танилцуулга

Монгол Улсад төсвийн эрх мэдэл төв засгийн газартаа ихээхэн төвлөрсөн гэж үздэг. Тухайлбал, 2011 оны байдлаар орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн Монгол Улсын нэгдсэн төсвийн тав хүрэхгүй хувьтай тэнцэж байна. Орон нутгийн түвшинд нийтэд үзүүлэх үйлчилгээний санхүүжилт нь төв засгийн газрын захиран зарцуулдаг улсын төсвөөс шууд (тухайлбал, нийтийн үйлчилгээний дийлэнх хэсгийг эзэлдэг эрүүл мэнд, боловсролын салбар), эсвэл орон нутгийн төсвөөс санхүүжиж ирсэн. Төсвийн үйл явцад дээрээс доош төлөвлөх болон хэрэгжүүлэх хандлага давамгайлсан, төсвийн төвлөрөл их байгаа зэрэг нь иргэд төсвийн үйл явцад идэвхтэй оролцох боломжийг хязгаарлахаас гадна орон нутгийн төр засгийн байгууллагууд иргэдийнхээ өмнө төсвийн талаар тайлагнах сонирхолгүй байхад нөлөөлж, улмаар иргэд ба төр засгийн байгууллага хоорондын үл ойлголцол, үл итгэлцэл арилахгүй хэвээр байна.

Сүүлийн жилүүдэд уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнэ, экспортын орлогын өсөлтийн ачаар улсын болон орон нутгийн төсвийн хэмжээ үлэмж нэмэгдэж байна. Ийм нөхцөлд иргэдийн зүгээс төсвийн төлөвлөлт, зарцуулалтанд тавих анхаарал нэмэгдэж байгаа ч иргэдэд мэдээллийг ил тод хүргэдэг, иргэдийн өмнө хариуцлага хүлээдэг хэвшсэн тогтолцоо төрийн байгууллагуудад дутагдаж байгаа нь ажиглагдаж байна. Ялангуяа хөрөнгийн зардал ихэд өссөн нь бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны туршлага багатай, өмнөх төслүүдийн үр ашгийг тэр бүр тооцдоггүй, иргэдийн хяналт сул байгааг харгалзан орон нутгийн хувьд шинэ сорилтуудыг бий болгож байна. Түүнчлэн эдийн засаг тэлж, төсвийн орлого, түүний дотор орон нутагт ихээхэн нөлөө үзүүлдэг уул уурхайн салбарын орлого нэмэгдэхийн хэрээр орон нутагт төсвийн илүү эрх мэдлийг олгохыг дэмжих чиг хандлагын дагуу төсвийн холбогдолтой хууль тогтоомжийг өөрчлөхөөр УИХ-ын түвшинд хэлэлцэж байна.

Хэдийгээр ахиц дэвшил гарч байгаа ч Монгол Улсын хувьд төсвийн ил тод байдал хангалтгүй түвшинд байгааг дэлхийн олон улс орныг хамруулан хийгддэг Нээлттэй Төсвийн Индекс-ийн 2006-2010 онуудын судалгаанаас харж болно. Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль дөнгөж энэ онд батлагдсан ба хэрэгжиж эхлээгүй байна. Төсвийн мэдээлэл нь нууцын зэрэглэлд ихэнх тохиолдолд хамаардаггүй ч амьдрал дээр жирийн иргэд төсвийн боловсруулалт, зарцуулалтын тухай дэлгэрэнгүй, баталгаатай мэдээллийг төрийн албан хаагчдаас тэр бүр авах боломжгүй байсаар байна. Ил тод байдлын талаарх иргэдийн хүсэлтийг орон нутгийн түвшинд төсвийн эрх мэдэл үгүй, төсвийн хэмжээ бага, төсвийг төр, засгийн байгууллагуул хянаж шийддэг гэх мэт шалтаг тойчин биелүүлэхгүй байх нь хэвшсэн соёл мэт болжээ. Мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж, уул уурхайн орлого үлэмж нэмэгдэж, төвлөрлийг сааруулах

шаардлагын талаар дээр дооргүй хэлэлцэж байгаа энэ цаг үед өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага байна. Ялангуяа уул уурхай эрчимтэй хөгжиж буй бүс нутагт иргэд уул уурхайгаас орон нутагт орж байгаа мөнгөний хэмжээ, түүний зарцуулалтын үр дүнгийн талаар илүүтэй сонирхож байгаагаас гадна бусад бүс нутгаас иргэд олноороо шилжин суурьших болсноор орон нутгийн төрийн үйлчилгээний болон нийгмийн дэд бүтцэд ихээхэн ачаалал нэмэгдэж байгаатай холбоотойгоор энэ асуудалд олон нийтийн анхаарал илүүтэйгээр хандах болжээ.

Өмнө нь гол төлөв хандивлагчдын дэмжлэгтэйгээр орон нутаг дахь төрийн чиг үүрэг, төсвийн эрх мэдэл, төв ба орон нутгийн засаг захиргааны харилцаа зэргийн талаар судалгаанууд хийгдэж байсан. Мөн орон нутгийн төр, захиргааны байгууллагууд дээд буюу төрийн байгууллагуудад мэдээлэл өгч, тайлагнах тогтолцоо бий. Харин төсвийн ил тод, нээлттэй байдлыг хөндлөнгийн байр сууринаас иж бүрэн үнэлэх оролдлого урд өмнө нь хийгдэж байгаагүй билээ. Тиймээс Орон нутгийн төсвийн ил тод байдал хэмээх энэхүү судалгаа нь Монгол улсад ил тод, нээлттэй байдлыг үнэлэх зорилгоор хийж буй анхны бие даасан судалгаа юм.

## Рейтинг

Хүснэгт 1-д уг судалгааны дүнгээр аймагууд ба нийслэл хотыг төсвийн ил тод нээлттэй байдлаар авсан нэгдсэн онооны дагуу эрэмбэлсэн жагсаалтыг үзүүлээ.

### Хүснэгт 1. Орон нутгийн төсвийн ил тод байдлын рейтинг

Аймаг / Нийслэл	Оноо I	Оноо II	Нийт оноо	Рейтинг
Улаанбаатар	80	45.0	55.5	1
Ховд	50	47.2	48.0	2
Сэлэнгэ	65	40.2	47.6	3
Булган	60	38.0	44.6	4
Архангай	50	42.2	44.5	5
Төв	50	36.0	40.2	6
Увс	35	39.9	38.4	7
Говьсүмбэр	60	28.9	38.3	8
Завхан	40	36.3	37.4	9
Өвөрхангай	55	29.3	37.0	10
Дорнод	40	35.0	36.5	11
Сүхбаатар	50	28.0	34.6	12
Хөвсгөл	45	29.0	33.8	13
Баянхонгор	55	22.7	32.4	14
Баян-Өлгий	30	33.2	32.3	15
Өмнөговь	25	31.7	29.7	16
Говь-Алтай	15	35.6	29.4	17
Дорноговь	10	35.9	28.2	18
Дархан-Уул	25	25.8	25.5	19
Хэнтий	20	19.9	19.9	20
Дундговь	25	15.0	18.0	21
Орхон	10	19.5	16.6	22
<b>Дундаж оноо</b>	<b>40.7</b>	<b>32.5</b>	<b>34.9</b>	

Энэ хүснэгтэнд үзүүлсэн аймгуудын авсан нийт оноо нь хоёр үндсэн хэсэг буюу дэд онооноос бүрдэнэ. Оноо I нь тус судалгаанд тусгайлан авч үзсэн төсвийн гол 10 баримт бичгийн иргэдэд хүртээмжтэй байдлыг үнэлсэн бол Оноо II нь судалгааны үндсэн асуулгын 60 асуултанд судлаачдын хариулснаар аймгуудын авсан оноог илэрхийлнэ. Уг 60 асуулт нь дараах гурван бүлгээс бүрдэнэ:



- (1) Төсвийн ил тод, нээлттэй байдлыг дэмжсэн эрх зүйн орчин (нийт 11 асуулт)
- (2) Нийтэд ил төсвийн гол баримт бичигт танилцуулсан мэдээллийн иж бүрэн байдал (нийт 38 асуулт)
- (3) Төсвийн үйл явцад иргэдийн оролцох боломжийг хангасан байдал (нийт 11 асуулт).

Орон нутгийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал нэн хангалтгүй байна. Нийт авч болох 100 онооноос аймгууд ба нийслэлийн авсан дундаж оноо ердөө 34.9 байв. Улаанбаатар хотын хувьд төсөвтэй холбоотой ихэнх мэдээллийг цахим хуудсанд байршуулсны дүнд авч болох онооны тэн хагасаас илүүг (55.5) авсан байна. Харин Хэнтий, Дундговь, Орхон аймгууд авах онооны 1/5-ыг ч авч чадаагүй нь үнэхээр чамлалттай үзүүлэлт юм. Хүн ам ихээр суурьшсан Дархан-Уул, Орхон, уул уурхайн үйл ажиллагаа идэвхтэй явагдаж буй Өмнөговь, Дорноговь аймгууд хангалтгүй дүн үзүүлсэн нь анхаарал татаж байна. Аймгуудыг бүсүүдээр ангилж авсан оноог харьцуулбал баруун аймгуудын дундаж 37.1, зүүн аймгуудын дундаж 30.3 оноо байна.

**Хүснэгт 2. Аймгуудын төсвийн ил тод байдлын рейтинг, бүс нутгаар**

Бүс нутаг	Нийт онооны дундаж
Нийслэл	55.5
Баруун	37.1
Хангай	34.8
Төв	32.5
Зүүн	30.3
<b>Дундаж оноо</b>	<b>34.9</b>

# 4

## Үр дүнгийн танилцуулга

Энэ хэсэгт бид эхлээд төсвийн мэдээллийн хүртээмжтэй байдлын талаарх үр дүнг танилцуулж, дараагаар нь орон нутгийн засаг захиргаанаас төсвийн ил тод, нээлттэй байдал, хариуцлагын тогтоолцоог нэмэгдүүлэх талаар хэрэгжүүлж байгаа туршлагаудтай холбоотой асуудлуудыг задлан шинжлэх болно.

### 4.1. Оноо I: Төсвийн мэдээллийн хүртээмжтэй байдал

Төсвийн ил тод байдлын судалгааг бэлтгэх явцад орон нутгийн түвшинд төсвийн үйл ажиллагаатай холбоотой олон тооны бичиг баримтыг судлаачид цуглуулж, шинжилсэн билээ. Ингэхдээ орон нутгийн төр захиргааны байгууллагууд боловсруулдаг, эсвэл ил тод байдал, оролцоог хангахын тулд боловсруулж болох төсвийн 10 гол баримт бичгийг түлхүү анхаарсан юм. Эдгээр 10 баримт бичиг олон нийтэд хүртээмжтэй байх нь төсвийн үйл явцад иргэд мэдээлэлтэйгээр, идэвхтэй оролцох угтвар нөхцөл болохоос гадна төсвийн төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотойгоор төрийн албан хаагч, эрх мэдэлтнүүдээс хариуцлагыг шаардах эхний алхам болох учиртай. Энэхүү судалгаа нь 21 аймаг, нийслэл хот хамарсан тул нийт 220 баримт бичгийг нарийвчлан судалсан болно.

Хүснэгт 3-д үзүүлснээр, нийт 220 баримт бичгийн зөвхөн 19.5 хувь нь л иргэдийн хувьд чөлөөтэй авч болдог, өөрөөр хэлбэл интернэт, номын сан, мэдээллийн самбар зэрэг сувгаар тусгайлан хүсэлт гаргалгүйгээр танилцаж болдог баримт бичиг байна. Мөн нийт баримт бичгийн 42 хувийг жирийн иргэд тусгайлан хүсэлт гаргаж байж орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас авах боломжтой байна. Цаашилбал, эдгээр баримт бичгийн 28 хувийг зөвхөн албан хэрэгцээнд зориулан боловсруулан гаргадаг дүнуг судалгаанаас харагдсан нь анхаарал татаж байна. Хамгийн ноцтой баримт бол төсвийн чухал баримт бичгүүдийн 10 хувийг огт боловсруулдаггүй гэсэн, эсвэл албан тушаалтнууд холбогдох хариултыг хэлж чадахгүй байсан явдал юм.

### Хүснэгт 3. Төсвийн гол баримт бичгийн нээлттэй байдал

Төсвийн баримт бичиг	Чөлөөтэй авч болдог	Хүсэлт гарган авч болдог	Зөвхөн албан хэрэгцээнд	Огт боловсруулдаггүй	Нийт
Аудитын тайлан	7	9	6		22
Батлагдсан төсөв	12	9	1		22
Жилийн тайлан	6	10	6		22
Сар бүрийн тайлан	4	5	10	3	22
Төсвийн санал	2	9	8	3	22
Төсвийн тодотгол	2	14	6		22
Төсвийн төсөл	3	16	3		22
Төсвийн хүрээ		8	12	2	22
Улирал тутмын тайлан	1	6	9	6	22
Хураангуй төсөв	6	7	1	8	22
Дүн	43	93	62	22	220
Дүн хувиар	19.5%	42.3%	28.2%	10.0%	100.0%

Судалж үзсэн 10 гол баримт бичгээс батлагдсан төсөв иргэдэд хамгийн их нээлттэй хүрдэг байна. 12 аймагт уг баримт бичгийг иргэд чөлөөтэй авч танилцах боломжтой байдаг бол мөн 9 аймагт тусгайлан хүсэлт гарган авах боломжтой ажээ. Харин Орхон аймагт батлагдсан төсвийг хүсэлт гаргаад ч авч чадаагүй нь томоохон бөгөөд харьцангуй хөгжилтэй аймгийн хувьд ноцтой асуудал юм. Түүнчлэн жилийн эцсийн төсвийн тайлан, аудитын тайлан зэргийг 16 аймагт нэг бол чөлөөтэй, эсвэл хүсэлт гарган авах боломжтой байв. Харин улирлын тайлан (7 аймагт), төсвийн хүрээ (8), сарын тайлан (9), төсвийн санал (11) зэрэг баримт бичгүүд зөвхөн цөөн хэдэн иргэдэд чөлөөтэй буюу хүсэлт гарган авах замаар хүртээмжтэй байгаа нь хангалтгүй дүн юм. Төсвийн хүрээ, улирлын тайлан, төсвийн тодотгол, төсвийн санал зэрэг чухал баримт бичгүүдийг хүсэлт гаргахгүй бол авах боломж үндсэндээ байхгүй нь анхаарал татаж байна. Сүүлийн жилүүдэд байнга хийгдэх болсон төсвийн тодотголын баримт бичгийг 6 аймагт иргэдэд огт ил болгохгүй, зөвхөн албан хэрэгцээнд зориулан гаргадаг дүн гарсан нь үнэндээ хамгийн наад захын төсвийн холбогдолтой мэдээллийг ч иргэд авч чадахгүй байгаагийн илрэл юм.

Төсвийн төлөвлөлттэй холбоотой баримт бичгүүдийн 66.6 хувь нь чөлөөтэй буюу хүсэлт гарган авч болох, харин тайлагнах үе шатны баримт бичгүүдийн 54.5 хувийг чөлөөтэй буюу хүсэлт гаргаж авч болохоор байна. Хураангуй төсвийг 8 аймагт боловсруулдаггүйг хүлээн зөвшөөрч болох ч улирлын тайланг 6 аймагт огт боловсруулдаггүй, төсвийн хүрээг 2, төсвийн санал, сар бүрийн тайланг тус бүр 3 аймагт огт боловсруулдаггүй гэсэн дүн гарсан нь үнэхээр бодит

байдлаас гадна гадна албан хаагчдын судлаачдад хандсан хандлагыг ч тодорхой хэмжээнд илэрхийлнэ. Төсвийг төлөвлөх үе шатны буюу төсвийн хүрээ болон төсвийн саналын баримт бичгийг үндсэндээ авч танилцах боломжгүй байгаа нь иргэдийн төсвийн үйл явцад, ялангуяа төлөвлөх үйл явцад эхнээс нь идэвхтэй оролцох боломжийг үндсэнд нь хааж байгаа хэрэг юм.

Төсвийн баримт бичгийн ил тод байдлыг бүс нутгаар авч үзвэл (Хүснэгт 4), нийслэл Улаанбаатар хотод төсвийн ихэнх баримт бичгийг цахим хуудаснаа байрлуулснаар иргэд чөлөөтэй үзэх боломжтой болсон нь ажиглагдав. Түүнчлэн зүүн аймгуудад дөрвөн баримт бичиг бүрийн нэгийг огт боловсруулдаггүй, мөн таван баримт бичгийн нэг нь зөвхөн албан хэрэгцээнд зориулагддаг нь анхаарал татлаа. Ийм тааруу дүн нь Дорнод, Хэнтий аймгуудад хураангуй төсөв, төсвийн хүрээ, төсвийн санал зэргийг огт боловсруулаагүй буюу холбогдох албан тушаалтнууд тодорхой хариу хэлж чадахгүй байснаас шалтгаалжээ. Баруун 5 аймагт ихэнх баримт бичгийг иргэд хүсэлт гарган авч болдог хэрнээ зөвхөн Ховд, Говь-Алтай аймгуудад л батлагдсан төсвийг чөлөөтэй авах боломжтой, харин нийт баримт бичгийн 58 хувийг хүсэлт гаргаж байж авах боломжтой байгаа нь иргэдэд ихээхэн хүндрэл учруулахаар байна. Төвийн бүсийн 7 аймагт нийт баримт бичгийн 47 гаруй хувийг огт боловсруулдаггүй буюу зөвхөн албан хэрэгцээнд зориулан гаргадаг байна.

#### Хүснэгт 4. Төсвийн баримт бичгийн ил тод байдал, бүс нутгаар


	Чөлөөтэй авч болдог	Хүсэлт гарган авч болдог	Зөвхөн албан хэрэгцээнд	Огт боловсруулдаггүй	Нийт /баримт бичгийн тоо/
Баруун	2.0%	64.0%	30.0%	4.0%	50
Зүүн	16.7%	40.0%	20.0%	23.3%	30
Нийслэл	80.0%	0.0%	20.0%	0.0%	10
Төв	20.0%	34.3%	35.7%	10.0%	70
Хангай	25.0%	41.7%	23.3%	10.0%	60
<b>Дүн хувиар</b>	<b>19.5%</b>	<b>42.3%</b>	<b>28.2%</b>	<b>10.0%</b>	<b>220</b>

Орон нутгийн засаг захиргаанаас төсвийн баримт бичгийг иргэд ямар сувгаар дамжуулан, авах боломжтойг судлаж үзсэнийг Зураг 1-д харууллаа. Орон нутагт төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх боломжтой олон суваг бий. Тухайлбал, 3 аймгаас бусад нь өөрийн гэсэн цахим хуудастай байсан бол Орхон, Увс, Дундговь аймгийн цахим хуудас судалгааны баримт цуглуулах хугацааны туршид ажиллахгүй байв. Нийтдээ төсвийн 220 баримт бичгийн 36 нь буюу дөнгөж 16 хувь нь интернэтийн цахим хуудсаар олон нийтэд хүрч байна.

Улаанбаатар хотод нийт 10 баримт бичгийн 8, Архангай, Сэлэнгэ аймгуудад 6-г нь интернэтээс авах боломжтой байгаа нь хамгийн эерэг дүн юм.


Бүх аймгийн төвд ажилладаг нийтийн номын сан, мөн олон аймагт байгуулагдсан интернэт, мэдээллийн төв зэрэгт төсвийн мэдээлэл тэр бүр тавигдаагүй нь энэ чухал бөгөөд хүртээмжтэй сувгийг ашиглан мэдээллийг олон нийтэд хүргэх боломжийг төр засгийн байгууллагууд ашиглахгүй байгааг илтгэнэ. Төр захиргааны байгууллагуудад бүгдэд нь гаргадаг мэдээллийн самбарт ч төсвийн тухай мэдээлэл тэр бүр тавигддаггүй байна. Мөн ихэнх баримт бичгийг зөвхөн албан хүсэлт гаргаж байж олж авахад хүрч байгаа нь орон нутгийн засаг захиргааны зүгээс өөрсдийн санаачлагаар мэдээллийг ил болгох байдал хангалтгүй байгааг харууллаа. Нийт 220 баримт бичгээс 136-тай нь иргэд хүсэлт гарган, эсвэл чөлөөтэй авч танилцах боломжтой байгаагаас 17-г нь тухайн баримт бичгийг боловсруулж гаргасан байгууллагаас нь бус, аймгийн санхүүгийн хэлтэс, эсвэл төсвийн төслийг ИТХ түүнийг боловсруулаагүй байгууллагаас авах боломжтой ажиглагдав. Орон нутгийн төсөв батлагдсантай холбогдуулан сэтгүүлчдэд тусгайлан мэдээлэл хийсэн тохиолдол бидний судалгаанд хоёр бүртгэгдсэн нь Улаанбаатар хот, ба Сэлэнгэ аймаг юм.

**Зураг 1. Төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх сувгууд**



Нийт 220 баримт бичгээс 136-г нь иргэд чөлөөтэй буюу хүсэлт гарган авах боломжтой байгааг дээр дурьдсан. Тэгвэл эдгээр 136 баримт бичгийг иргэд олж авахад хэр цаг хугацаа шаардагдсаныг Зураг 2-т үзүүлээ. Ил болж буй баримт бичгийн 21 хувийг боловсруулагдаж бэлэн болсноос хойш долоо хоногийн дотор олж авсан бол 16 хувийг сар илүү хугацааны дараа танилцах боломжтой байгаа нь мэдээллийг шуурхай түгээх, улмаар иргэдийн оролцоог хангах боломжийг хязгаарлаж байна.

**Зураг 2. Төсвийн баримт бичгийг иргэдэд хүргэх цаг хугацаа  
(нийт 136 баримт бичиг)**



Ийнхүү төсвийн гол баримт бичгүүд олон нийтэд ил тод байгаа эсэхэд нь оноо өгч, аймгуудыг авсан дундаж оноогоор нь жагсаасныг Хүснэгт 5-д үзүүлээ. Ингэхдээ иргэд чөлөөтэй авч болох баримт бичигт 100 оноо, хүсэлт гарган авч болох баримт бичигт 50 оноо тус бүр өгсөн болно. Улаанбаатар хотын хувьд нийт 10 баримт бичгийн 8-ийг нь цахим хуудаснаас нь чөлөөтэй авах боломжтой байсан тул энэ хэсэгт өндөр оноо авчээ. Гэтэл Орхон, Дорноговь, Өмнөговь зэрэг дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн, уул уурхайн баялаг ихтэй, төсвийн орлого их байх магадлалтай аймгуудын хувьд тааруухан оноо авсан нь анхаарал татаж байна. Төсвийн мэдээллийн ил тод байдлыг үнэлсэн энэхүү Оноо I нь Төсвийн ил тод байдлын эцсийн рейтингийн нэгдсэн оноог гаргахад 30 хувийн жин дарахаар тооцсон болно.

**Хүснэгт 5. Төсвийн гол 10 баримт бичгийн ил тод байдал: Оноо I**

Аймаг / Нийслэл	Хүсэлт гарган авч болдог	Чөлөөтэй авч болдог	Оноо I
Улаанбаатар		8	80
Сэлэнгэ	5	4	65
Булган	4	4	60
Говьсүмбэр	4	4	60
Баянхонгор	5	3	55
Өвөрхангай	5	3	55
Архангай	4	3	50
Сүхбаатар	4	3	50
Төв	4	3	50
Ховд	8	1	50
Хөвсгөл	7	1	45
Дорнод	4	2	40
Завхан	8		40
Увс	7		35
Баян-Өлгий	6		30
Дархан-Уул	1	2	25
Дундговь	5		25
Өмнөговь	3	1	25
Хэнтий	4		20
Говь-Алтай	3		15
Дорноговь	2		10
Орхон		1	10
Дүн	93	43	
<b>Дундаж оноо</b>			<b>40.7</b>

#### 4.2. Оноо II: Ил тод, нээлттэй байдлын эрх зүйн орчин ба бодит байдал

Судалгааны асуулгын үндсэн хэсэг болох 60 асуултанд үндэслэн Оноо II-г гаргаж, аймгуудыг жагсаасан дүнг Хүснэгт 6-д танилцуулав. Тус хүснэгтэнд танилцуулсан дундаж оноо нь 32.5 байгаа нь орон нутгийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал маш хангалтгүй түвшинд байгааг илтгэнэ. Хамгийн өндөр оноотой Ховд аймаг гэхэд боломжит 100 онооны талыг ч авч чадаагүй бол хамгийн бага буюу ердөө 15 оноог Дундговь аймаг авсан нь туйлын чамлалттай.

Оноо II-г бүс нутгаар харьцуулан үзвэл нийслэл хот хамгийн өндөр оноо авсан бол баруун аймгуудаас бусад бүс нутгийн аймгууд ерөнхийдөө ойролцоо үзүүлэлттэй байгааг Хүснэгт 7-д танилцуулав.

##### Хүснэгт 7. Дундаж оноо, бүс нутгаар

Бүс нутаг	Оноо II дундаж
Нийслэл	45.0
Баруун	38.4
Төв	30.5
Хангай	30.1
Зүүн	27.6
<b>Дундаж</b>	<b>32.5</b>

Асуулгад орсон 60 асуултын онооны дундаж нь Оноо II-г бүрдүүлж байгаа ба 1-11-р асуултаар нь төсвийн ил тод, нээлттэй байдлыг дэмжсэн эрх зүйн орчныг үнэлэхийг зорьсон бол 11-48-р асуулт нь нийтэд ил төсвийн гол баримт бичигт танилцуулсан мэдээллийн иж бүрэн байдлыг, харин 49-60-р асуултууд нь төсвийн үйл явцад иргэдийн оролцох боломжийг хангасан байдлыг үнэлэхийг зорьсон. Эдгээр асуултын бүлэгт тус бүрээр аймгуудын авсан дундаж оноог

##### Хүснэгт 6. Аймаг нийслэлийн төсвийн ил тод байдлын рейтинг: Оноо II

Аймаг / Нийслэл	Оноо II	Рейтинг
Ховд	47.2	1
Улаанбаатар	45.0	2
Архангай	42.2	3
Сэлэнгэ	40.2	4
Увс	39.9	5
Булган	38.0	6
Завхан	36.3	7
Төв	36.0	8
Дорноговь	35.9	9
Говь-Алтай	35.6	10
Дорнод	35.0	11
Баян-Өлгий	33.2	12
Өмнөговь	31.7	13
Өвөрхангай	29.3	14
Хөвсгөл	29.0	15
Говьсүмбэр	28.9	16
Сүхбаатар	28.0	17
Дархан-Уул	25.8	18
Баянхонгор	22.7	19
Хэнтий	19.9	20
Орхон	19.5	21
Дундговь	15.0	22
<b>Дундаж оноо</b>	<b>32.5</b>	



Хүснэгт 8-д танилцуулав. Үүнд ялангуяа ил тод, нээлттэй байдлыг хангахын тулд тодорхой дүрэм, журам, шийдвэр гаргах боломж орон нутгийн ИТХ, Засаг даргад байгаа ч тэр бүр санаачлан хэрэгжүүлдэггүй болохыг тус бүлгийн асуултын дундаж оноо ихээхэн доогуур (17.3) байгаагаас харж болно. Харин мэдээллийн иж бүрэн байдал, төсвийн үйл явцын нээлттэй байдалтай холбоотой асуултууд ойролцоо дундаж оноотой ч тус бүр 35.1 ба 38.1 тун доогуур үзүүлэлт юм.

#### Хүснэгт 8. Асуултын төрөл тус бүрээр авсан дундаж оноо

Бүлэг асуултууд	Дундаж оноо
Төсвийн ил тод байдлын эрх зүйн орчин	17.3
Төсвийн мэдээллийн иж бүрэн байдал	35.1
Төсвийн үйл явцын нээлттэй байдал	38.1

Дээрх гурван бүлэг асуултын хувьд аймгуудыг авсан оноогоор нь Хүснэгт 9-д эрэмблэн жагсаав. Төсвийн ил тод, нээлттэй болгох асуудлыг бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан байдлын хувьд Төв аймаг харьцангуй өндөр оноо авсан бол найман аймаг таван оноо ч авч чадсангүй. Нийтэд дэлгэсэн төсвийн мэдээллийн иж бүрэн байдлын үзүүлэлтээр Улаанбаатар хот, Ховд, Увс аймгууд тэргүүлсэн бол Дундговь, Орхон, Хэнтий зэрэг аймгууд туйлын хангалтгүй дүн үзүүлжээ. Харин төсвийн үйл явцын нээлттэй байдлын хувьд Дорноговь, Ховд, Дорнод аймгууд бусдаас илүү байсан бол Баян-Өлгий, Дундговь, Өвөрхангай аймгууд илт хоцорчээ.

#### Хүснэгт 9. Асуултын төрөл тус бүрээр аймгуудын авсан дундаж оноо, эрэмбэ

Аймаг / нийслэл	Төсвийн ил тод байдлын эрх зүйн орчин		Төсвийн мэдээллийн иж бүрэн байдал		Төсвийн үйл явцын нээлттэй байдал	
	Оноо	Байр	Оноо	Байр	Оноо	Байр
Архангай	30.3	5	45.9	4	41.5	10
Баян-Өлгий	4.8	16	45.4	5	21.6	22
Баянхонгор	4.8	16	25.5	18	30.5	16
Булган	32.6	2	36.6	11	47.0	5
Говь-Алтай	21.2	10	41.4	7	31.3	15
Говьсүмбэр	4.8	16	30.8	14	45.2	8
Дархан-Уул	8.5	14	25.5	18	42.3	9
Дорноговь	32.6	2	30.6	16	55.5	1
Дорнод	23.6	7	33.0	13	51.3	3

Дундговь	9.1	13	14.4	22	22.1	21
Завхан	13.9	11	39.9	9	45.6	7
Орхон	4.8	16	17.6	21	38.8	11
Өвөрхангай	4.8	16	37.7	10	25.8	20
Өмнөговь	4.8	16	40.9	8	27.6	18
Сүхбаатар	3.9	22	33.2	12	34.1	14
Сэлэнгэ	23.0	8	43.5	6	45.8	6
Төв	48.5	1	27.7	17	49.8	4
Увс	23.0	8	49.0	3	27.2	19
Улаанбаатар	30.3	5	52.8	1	34.6	13
Ховд	31.8	4	49.7	2	53.5	2
Хөвсгөл	12.1	12	30.8	15	38.8	11
Хэнтий	7.5	15	20.7	20	28.6	17
<b>Дундаж оноо</b>	<b>17.3</b>		<b>35.1</b>		<b>38.1</b>	

Одоо эдгээр үзүүлэлттэй холбоотой зарим нэгэн дэлгэрэнгүй дүн шинжилгээг танилцуулъя.

***Төсвийн мэдээллийг ил тод, төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгох талаар бодлогын ба эрх зүйн баримт бичигт туссан байдал***

Орон нутгийн эрх баригчид өөрсдийн гаргасан дүрэм, журам, бусад шийдвэрээр дамжуулан төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх, төсвийн хэлэлцүүлэгт оролцуулах боломжийг нэмэгдүүлэх өргөн боломжтой. Энэхүү боломжийг аймгууд хэрхэн ашиглаж байгааг үнэлсэн 11 асуултанд бусад асуулттай харьцуулахад хамгийн бага дундаж оноо буюу ердөө 17.3 оноог авсныг Хүснэгт 9-өөс харж болохоор байна. Гэхдээ энэ үзүүлэлтээр хамгийн бага оноо авсан Сүхбаатар (3.9), хамгийн их оноо авсан Төв (48.5) аймгийн хооронд ихээхэн зөрүү байгаа нь ил тод, нээлттэй байдлын эрх зүйн орчныг бэхжүүлэхэд орон нутгийн удирдлагууд илүү идэвхи санаачлагатай ажиллах боломжтойг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан аймгуудаас Хөвсгөл, Ховд, Төв аймгуудад ИТХ-ын зүгээс төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх чиглэлээр тогтоол шийдвэр гаргажээ. Тухайлбал, Хөвсгөл аймгийн хувьд Иргэний танхим байгуулах шийдвэрийн хамт төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг шийдвэрлэсэн байна. Харин Архангай, Говь-Алтай аймгууд, Улаанбаатар хотод Засаг даргын зүгээс төсвийн мэдээллийг иргэдэд хүргэж байх албан шийдвэр гаргажээ. Тухайлбал, нийслэлийн засаг даргын 2010 оны 392 дугаар журам болон 03-р захирамжид

төсвийн тайлан мэдээг олон нийтэд ил тайлагнах зарчмыг хэрэгжүүлэх тухай дурьдсан ч төдийлөн тодорхой биш заалтууд орсон байв. Харин Говь-Алтай аймгийн хувьд ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Монгол Улсын Засгийн газрын 143-р тогтоолыг хэрэгжүүлэх асуудлаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2009 оны 36 тоот тушаал гарч төлөвлөгөө баталсны дотор төсөв санхүүгийн ил тод байдлын талаар долоон асуудал тусгагджээ.

Засаг даргын үйл ажиллагааны буюу мөрийн хөтөлбөрт төсвийн ил тод, нээлттэй байдлын тухай таван аймаг (Ховд, Дорнод, Дорноговь, Төв, Булган), мөн Улаанбаатар хотын хувьд тодорхой заалтууд тусгалаа олжээ. Тухайлбал, нийслэлийн Засаг даргын 2008-12 оны үйл ажиллагаан хөтөлбөрт “хуулиар зөвшөөрөгдсөн мэдээлэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг олон нийтэд нээлттэй болгоно” гэсэн тодорхой заалт оржээ. Харин Дорнод аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт “Жилийн төсөв, санхүүгийн зарцуулалтыг 2008 оны гүйцэтгэлээс эхлэн жил тутам дэлгэрэнгүй мэдээлж, ил тод болгох арга хэмжээ авна” хэмээн тусгасан байна.

Зөвхөн Архангай аймагт ИТХ, Засаг даргын хооронд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд төсвийн ил тод, нээлттэй байдлын тухай ерөнхий заалт оруулжээ. Тухайлбал, 2011 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд Засгийн газрын 143-р тогтоолыг хэрэгжүүлэх тухай заажээ. Харин зарим аймагт ийм гэрээг огт байгуулдаггүй болохыг судалгааны явцад тогтоосон нь “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн холбогдох заалт, тухайлбал аймаг, нийслэлийн ИТХ “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүний тоо хэмжээг тогтоож батлах, бүтээгдэхүүн нийлүүлэх талаар Засаг даргатай гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах” тухай 50.1.3-р заалтыг зөрчиж байгаа явдал юм. Дундговь, Төв аймгуудад Засаг дарга, ЗДТГ-ын даргын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээнд Тамгын газрын даргын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурт төсвийн ил тод байдлыг хангах тухай заалт орсон байна. Харин Дархан-Уул, Дорноговь аймгуудад ЗДТГ-ын дарга, санхүүгийн асуудал хариуцсан хэлтсийн дарга нарын хооронд байгуулсан үр дүнгийн гэрээнд төсвийн ил тод, нээлттэй байдлын тухай шалгуур үзүүлэлт оруулжээ.

Тухайлбал, Дундговь аймгийн ИТХ, Засаг даргын хооронд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 тоот тогтоолын заалтуудыг хуулбарлан оруулсан байна. Дархан-Уул аймгийн санхүүгийн асуудал хариуцсан хэлтсийн даргын үр дүнгийн гэрээнд “төсвийн” гэж тодотгоогүй ч мөн дээрх 143 тоот тогтоол, 2009 оны 03 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах зорилгоор “ил тод нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтийг хангах” гэж заасан байна. Таван аймгийн хувьд Засаг дарга, эрүүл мэндийн эсвэл боловсролын газрын дарга нартай байгуулсан

гэрээнд төсвийн ил тод байдлын тухай оруулсан байгаа нь мөн л 143 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай байв. Сэтгүүлчдэд төсвийн тухай мэдээлэл өгч байх зохицуулалтыг Ховд болон Дорнод аймагт хийсэн байгаа ба тухайлбал Ховд аймагт ИТХ-аас хэд хэдэн телевизтэй мэдээлэл түгээх талаар гэрээ хийсэн байна.

Энэ хэсгийн хамгийн өндөр оноо авсан Төв аймгийн хувьд 2010 онд ИТХ-аас төсвийг ил тод болгоход чиглэсэн тогтоол гаргасан ба Засаг даргын мөрийн хөтөлбөрт төсвийг ил болгоход чиглэсэн зорилт тусгагдсан, мөн Засаг даргын тамгын газрын дарга болон санхүүгийн асуудал хариуцсан хэлтсийн даргын үр дүнгийн гэрээнд төсвийг олон нийтэд хүргэх талаар тодорхой зорилтууд дэвшүүлсэн нь харьцангуй өндөр оноо авахад нөлөөлжээ. Харин хамгийн бага оноо авсан Сүхбаатар аймгийн хувьд төсвийг ил, нээлттэй болгох ямар нэгэн эрх зүйн шаардлага бүхий баримт бичгийг санаачлан боловсруулаагүй байна.

### ***Төсвийн үндсэн баримт бичгүүд дэх мэдээллийн иж бүрэн байдал***

Иргэдэд ил болгох шаардлагатай төсвийн арван чухал баримт бичгийн иж бүрэн байдал, мөн иргэд төсвийн үйл явцад идэвхтэй оролцох боломжийг хангахуйц хугацаанд мэдээллийг ил болгож байгаа эсэхийг үнэлсэн 38 асуултанд орон нутгийн засаг захиргааны авсан дундаж оноо нь нийт авч болох 100-аас ердөө 35.1 байгаа нь ихээхэн хангалтгүй дүн юм. Энэ үзүүлэлтээр Улаанбаатар хотын оноо хамгийн өндөр буюу 52.8 байхад хамгийн муу оноо авсан Дундговь аймгийн дүн 14.4 байгааг Хүснэгт 9-д үзүүлэв.

Төсвийн төлөвлөлт Засгийн газраас *төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг* боловсруулахаар эхэлдэг ба орон нутгийн хувьд ч өөрсдийн саналыг Сангийн яаманд хүргүүлдэг билээ. Харамсалтай нь энэ үйл явц иргэдийн хувьд нэн бүрхэг, хаалттай явагддаг болохыг судалгааны дүн харууллаа. Тухайлбал, гурван аймагт (Говь-Сүмбэр, Завхан, Ховд) төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг иргэд хүсэлт гаргавал үзүүлж болно гэж орон нутгийн засаг захиргааныхан мэдэгдсэн бол бусад аймагт энэхүү саналыг иргэдэд огт ил болгодоггүй байна. Төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсаны дараа орон нутгийн *төсвийн саналыг* тухайн оны долдугаар сард бэлтгэн, Сангийн яаманд илгээдэг ба энэ баримт бичгийг ч олон нийтэд ил болгодоггүй, харин иргэд өөрсдөө хүсэлт гаргавал дөрвөн аймагт үзүүлж болно гэсэн хариулт өгчээ. Өөрөөр хэлбэл орон нутгийн төсвийг төлөвлөх эхний үе шатанд иргэд саналтай танилцах, өөрсдийн саналыг тусгуулах бололцоо үнэн хэрэгтээ алга байна.

Төлөвлөлтийн дараагийн үе шат бол Засаг даргын зүгээс Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ирэх жилийн *төсвийн төлөвлөгөөг* албан ёсоор танилцуулах явдал байдаг. ИТХ нь шууд сонгогдсон иргэдийн төлөөллийн

байгууллага тул төсвийг батлахад иргэдийн эрх ашгийг хамгаалах учиртай хамгийн чухал бүтэц юм. Төсвийн төлөвлөгөөг ийнхүү иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцэн баталдаг тул төсөв төлөвлөлтийн үе шатан дах хамгийн чухал баримт бичиг болж өгдөг. Тиймээс ч төсвийн төлөвлөгөө нь иж бүрэн мэдээллийг агуулсан, орон нутгийн засаг захиргааны ирэх жилд хийх үйл ажиллагааг нэн тодорхой тайлбарласан баримт бичиг байх учиртай. Хэрвээ энэхүү баримт бичгийг батлагдахаас нь өмнө иргэд танилцах боломжтой бол өөрсдийн санал бодлыг тусгуулах боломж бүрдэж, улмаар төсвийн төлөвлөлтийг бүхэлд нь нээлттэй болгоход ихээхэн ач холбогдолтой юм. Эдгээр учир шалтгаанаас уг судалгаанд нийт 15 асуултыг зөвхөн төсвийн төлөвлөгөөний баримт бичигтэй холбоотойгоор оруулж, судалсан юм. Орон нутгийн засаг захиргааны авсан дүнг авч үзвэл нийт асуултын 1/3-т нь эерэг буюу боломжийн, харин үлдсэн хэсэгт нь сөрөг буюу хангалтгүй дүн авсан нь төсвийн төлөвлөгөөний баримт бичиг нь хангалттай мэдээлэл харуулж байна. Нөгөө талаар төсвийн төлөвлөгөөг бэлтгэх, өргөн барих, хэлэлцэн батлах үйл явцыг сайжруулах, илүү нээлттэй, хариуцлагатай болгох шаардлага, бас боломж байсан гэсэн үг юм.

Илүү нарийвчлан авч үзвэл, Дорноговь, Орхон, Төв аймгуудад төсвийн төлөвлөгөө буюу төслийг боловсруулдаг ч иргэд ИТХ-аар дамжуулан авах боломжгүй байна. Мөн зөвхөн Булган, Сэлэнгэ, Улаанбаатарт л төсвийн төслийг иргэд чөлөөтэй авах боломжтой, харин бусад бүх аймгуудад иргэд зөвхөн албан ёсоор хүсэлт гарган байж авч танилцахад хүрч байна. Архангай аймагт иргэд хүсэлт гарган байж төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцэхээс өмнө олж үзэх боломжтой байгааг эс тооцвол төсвийн төслийг батлагдахаас нь өмнө аль ч аймагт танилцах боломжгүй байгаа нь иргэдийн төсвийн төлөвлөлтийн үйл явцад оролцоход ихээхэн бэрхшээл учруулж байгаа нь ойлгомжтой. Төсвийн төслийг иргэдэд танилцуулах боломжийн талаар тодруулахад зарим аймгийн албан тушаалтнууд цаг хугацааны хувьд энэ нь хүндрэлтэй болохыг учирлаж байв. Цаашилбал, төсвийн төслийг Засаг даргын зүгээс ИТХ-д өргөн барихаас өмнө олон нийтэд ил болгох явдал хангалтгүй байгаад зогсохгүй, ИТХ-ын гишүүд ч төсвийн төсөлтэй танилцах хугацаа хэт давчуу байна. Тодруулбал, 15 аймагт төсвийн төслийг ИТХ-д хэлэлцэн батлахаас ердөө долоо хоногийн өмнө ирүүлсэн, мөн нэг аймагт долоо хоног хүрэхгүй хугацаанд ирүүлжээ. Зарим тохиолдолд ИТХ-д албан ёсоор өргөн барьсан төсвийн төсөл төлөөлөгчдийн гар дээр очтол ихээхэн хугацаа алддаг нь ИТХ-ын дотоод ажлаас хамаарсан асуудал юм.

Төсвийн орлого, зарлагын тухай мэдээллийн иж бүрэн байдалтай холбоотой асуултуудад ч аймгууд хангалттай дүн авч чадсангүй. 10 аймагт төсвийн төсөлд зарлагыг эдийн засгийн, байгууллагын болон хөтөлбөрийн зэрэг ангиллаар

ангилж байхад дөрвөн аймагт (Дундговь, Хөвсгөл, Төв, Орхон) төсвийн төсөл нь ердөө нэг ангиллаар, тухайлбал байгууллагын ангиллаар танилцуулагдаж байгаа нь ИТХ-д шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл өгөхгүй байгаагийн жишээ юм. Мөн зарлагын талаарх ирэх жилийн төсвийн мэдээллийг зургаан аймагт өмнөх жилийн үзүүлэлтүүдтэй харьцуулсан байдлаар танилцуулаагүй байна. Мөн төсвийн төсөл дэх тоон мэдээллийг дэлгэрэнгүй тайлбартайгаар танилцуулдаг гуравхан аймаг байхад нийт 12 аймагт төсвийн тоон мэдээлэлд тайлбар хавсаргаагүй байна. Мөн ирэх төсвийн жилээс цааш төсвийн зарлага хэрхэн өөрчлөгдөх талаархи төсөөллийг төсвийн баримт бичигт ихэнхдээ оруулдаггүй байна (Тодруулбал, аймагт ийм төсөөллийг огт хийгээгүй). Гурван аймагт л төсвийн хэмжээг аймгийн нийт эдийн засаг, мөн инфляцийн түвшинтэй уялдуулан бодит байдлаар хэрхэн өөрчлөгдөхийг тайлбарлахыг оролдсон бол бусад 19 аймагт ийм мэдээлэл огт алга байна.

Төсвийн орлогын талаар ч төсвийн төсөлд тийм ч хангалттай дэлгэрэнгүй байдлаар танилцуулдаггүй байна. Тухайлбал, төсвийн орлогын янз бүрийн эх үүсвэрүүд болох улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс шууд санхүүжих орон нутагт үзүүлдэг төрийн үйлчилгээний санхүүжилт зэргийг таван аймаг төсвийн төсөлдөө тусгаагүй нь ажиглагдав. Зөвхөн зургаан аймагт л орлого төвлөрүүлэгч байгууллага, салбар, мөн орлогын нэр төрлөөр нь орлогын төлөвлөгөөг танилцуулдаг бол долоон аймагт эдгээрийн хоёр үзүүлэлтээр, мөн зургаан аймагт аль нэг үзүүлэлтээр л орлогыг задлан танилцуулдаг байна. Мөн тухайн төсвийн жилд төвлөрөх орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын орлогын гүйцэтгэлтэй таван аймагт огт харьцуулдаггүй, харин 10 аймагт зөвхөн өмнөх жилтэй л харьцуулсан мэдээллийг төсөлд оруулжээ. Аймгуудын ихэнхи буюу 13 нь төсвийн төсөлдөө тухайн аймгийн төсөвт онцгой нөлөөтэй салбарууд, тухайлбал уул уурхай, хөдөө аж ахуй зэрэг салбараас төвлөрөх орлогын талаар тусгайлан тайлбар хийдэггүй, мөн төсвийн орлогод учирч болох эрсдлийн талаар нэг л аймгийн төсөлд тайлбар өгсөн нь төсвийн орлогод учирч болох эрсдлийн талаар орон нутгийн түвшинд тооцоолж үздэггүйг харуулж байна.

Цаашилбал, төсвийн төсөлд орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүд, мөн аймаг хөгжүүлэх сангуудын тухай мэдээлэл хангалттай бус байна. Зөвхөн таван аймгийн төсвийн төсөлд орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн холбогдолтой зарим нэг мэдээлэл орсон бол бусад бүх аймагт ийм төрлийн мэдээллийг огт тусгаагүй байна. Аймаг хөгжүүлэх сангуудын тухай зарим мэдээллийг таван аймгийн төсвийн төсөлд танилцуулсан бол бусад бүх аймгийн төсөлд ийм төрлийн мэдээлэл ороогүй нь танилцуулж буй мэдээллийн иж бүрэн байдал тун хангалтгүйг харууллаа. Эцэст нь хоёр аймгийн төсвийн төсөлд график дүрслэл зэргийг нэлээд өргөн, өөр дөрвөн аймгийн төсөлд цөөн тооны график дүрслэл ашиглажээ. Бусад аймгуудын төсөлд график дүрслэл байгаагүй

нь тэд төсвийн баримт бичгийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, хялбар байх талаар санаа тавьдаггүйг харууллаа.

Орон нутгийн төсвийн төсөл ИТХ-аар хэлэлцэн, эцсийн байдлаар баталдаг билээ. Батлагдсан төсөв нь төсвийн бусад баримт бичигтэй харьцуулахад олон нийтэд хамгийн ихээр хүрдэг баримт бичиг байна (Хүснэгт 3). Уг баримт бичгийг 12 аймагт иргэд чөлөөтэй авч болох бол 9 аймагт хүсэлт гарган авч болдог, харин нэг аймагт иргэд авах боломжгүй байв. Нэгэнт ИТХ-ын албан ёсны шийдвэр учир иргэдэд нээлттэй хүрэх нь зүй ёсны хэрэг ч Орхон аймагт уг баримт бичгийг олж авах боломжгүй байсан, мөн олон аймагт заавал хүсэлт гаргаж байж уг баримт бичигтэй танилцах боломж нээгдэж байгааг хүлээн зөвшөөрөх аргагүй юм. Олон нийтэд танилцуулж байгаа батлагдсан төсвийн задаргааг авч үзвэл 12 аймагт төсвийг зөвхөн байгууллагын ангиллаар үзүүлсэн байв. Харин төсвийг зөвхөн байгууллагын бус эдийн засгийн, мөн чиг үүргийн ангиллын дагуу олон нийтэд танилцуулсан нь Булган, Дорнод, Төв аймгууд юм. Мөн батлагдсан төсвийг 14 аймагт зөвхөн тоон мэдээлэл хэлбэрээр, өөрөөр хэлбэл ямар нэгэн нэмэлт тайлбаргүйгээр олон нийтэд хүргэдэг бол долоон аймагт хураангуй тайлбарын хамт танилцуулжээ. “Урсгал төсвийг иргэд ойлгохгүй тул нарийн мэдээлэл өгөх шаардлагагүй” гэх тайлбарыг ч зарим албан тушаалтнууд судалгааны үеэр өгч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Тиймээс эрх бүхий байгууллагаар нэгэнт батлагдсан төсвийг олон нийтэд дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар хүргэх тал дээр онцлон анхаарч ажиллах шаардлагатай нь эргэлзээгүй юм.

Төсвийн жил нэгэнт эхэлснээс хойш батлагдсан төсөвт ямар нэгэн өөрчлөлт оруулахаар тодотгох явдал ялангуяа сүүлийн жилүүдэд бараг хэвийн үзэгдэл болжээ. Нэгэнт төсвийн байгууллагын зарцуулах бодит мөнгийг энэхүү тодотголоор эцэслэн тогтоож байгаа тул тодотголын төсөл, түүнийг хэлэлцэн батлах үйл явц, батлагдсан тодотголыг олон нийтэд хүргэх нь оны эхэнд төсөв батлахтай адил шаардлагад нийцэх учиртай ч тэгэж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдав. Тухайлбал, аймгуудад төсвийн тодотголын төслийг ИТХ-д танилцуулахаас өмнө Засаг даргын зүгээс олон нийтэд огт танилцуулдаггүй байна. Мөн 10 аймагт тодотголын төслийг ИТХ-аар хэлэлцэхээс 3 хоногийн өмнө л өргөн барьдаг нь хугацаа тулгамдаж, төсөлтэй ИТХ-ын төлөөлөгчид нарийн сайн судалж танилцах саналаа бэлтгэхэд хангалтгүй юм. Найман аймагт төсвийн тодотголын төслийг Засаг даргаас ИТХ-д өргөн барихдаа зөвхөн тодотгол хийх зүйлийг л тайлбарын хамт танилцуулдаг бол долоон аймагт тайлбаргүйгээр, зөвхөн тодотгох орлого, зарлагын зүйлийг танилцуулжээ. Харин Орхон, Дархан-Уул аймгуудад тодотголын тухай мэдээллийг олон нийтэд огт ил болгодоггүй тул энэ асуултанд хариулах боломжгүй байв. Мөн тодотгосон төсвийг найман аймагт олон нийтэд огт ил болгохгүй байгаа бол



мөн найман аймагт батлагдсанаас хойш нь сарын дараа, өөр нэг аймагт гурван сарын дараа л олон нийтэд ил хүргэсэн нь маш их цаг хугацаа алдсан хэрэг юм. Мөн дийлэнх буюу 13 аймагт тодотгосон төсвийн баримт бичигт зөвхөн тодотгол хийсэн төсвийн зүйлүүдийг жагсааж олон нийтэд хүргэжээ. Тиймээс оны эхэнд батлагдсан төсөв бүхэлдээ ямар байдлаар өөрчлөгдсөнийг иргэд тэр бүр мэдэх боломжгүй юм.

Төсвийн хөрөнгийн зарцуулалтыг илтгэх, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд онцгой ач холбогдолтой баримт бичиг бол төсвийн тайлангууд юм. Тиймээс ч эдгээр тайланг уг төсвийн төсөл ба гүйцэтгэлийг хэлэлцэж баталдаг ИТХ болон олон иргэд, олон нийтэд шуурхай, бүрэн дүүрэн хүргэж байх нь маш чухал. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн явцын тайланг Засаг даргын зүгээс ИТХ-д сар тутам хүргэдэг хоёр аймаг, улирал тутам хүргэдэг нэг аймаг, хагас жил тутамд хүргэдэг долоон аймаг байхад үлдсэн 12 аймаг нь уг мэдээллийг жилд ганц удаа хүргэж байгаа нь төсвийн гүйцэтгэлийн талаар ИТХ-ын төлөөлөгчид мэдээлэл багатай, өөрсдийн баталсан төсвийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих, хариуцлага шаардах боломж хомс байдгийг илтгэж байна. Мөн уг тайланг олон нийтэд ил тод болгох явдал ч хангалтгүй байгааг огт танилцуулдаггүй таван аймаг, жилд нэг удаа танилцуулдаг есөн аймгийн жишээ харууллаа. Төсвийн жилийн эцсийн тайланг ИТХ-аар хэлэлцэн баталдаг, гэтэл үүнийг үүнийг шуурхай, цаг алдалгүй хийж чадахгүй байна. Есөн аймагт энэхүү хэлэлцүүлгийг төсвийн жил дууссанаас таван сарын дотор, гурван аймагт долоон сарын дотор, хоёр аймагт 10 сарын дотор, харин таван аймагт бараг бүтэн жилийн дараа хэлэлцэн баталдаг байна. Мөн Ховд, Хэнтий, Дорнод аймгуудад өмнөх жилийн төсвийн гүйцэтгэлийг хэзээ, хэрхэн хэлэлцэж баталсан тухай мэдээлэл олдоогүй буюу өгөөгүй тул огт хэлэлцээгүй гэж дүгнэхэд хүрлээ. Төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг Дундговь, Хэнтий, Төв, Сүхбаатар, Орхон, Дорноговь, Говьсүмбэр зэрэг долоон аймагт олон нийтэд мэдээлээгүй, дөрвөн аймагт байгууллагын эсвэл эдийн засгийн ангиллын аль нэгээр нь, найман аймагт аль аль ангиллаар нь танилцуулсан нь жилийн эцсийн тайлангийн чанар, хүртээмж хангалтгүй байгааг илэрхийлнэ. Мөн батлагдсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулсан мэдээллийг 14 аймагт төсвийн тайланд тусгадаг ч 10-т нь аливаа гарсан зөрүүний шалтгааныг тайлбарлаагүй байна. Үлдсэн найман аймагт төсвийн төлөвлөгөөг бодит гүйцэтгэлтэй харьцуулсан мэдээллийг ил болгосонгүй. Цаашилбал, орон нутгийн төсөвт сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилт чухал байр суурийг эзлэх болсон ч тайланд түүний төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулсан мэдээллийг 11 аймагт огт танилцуулаагүй бол таван аймагт цөөн хэдэн төслийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг танилцуулж, дөрвөн аймагт төсөл тус бүрээр харьцуулан танилцуулсан ба өөр хоёр аймагт төслүүдийн төлөвлөгөө төлөвлөгөө, гүйцэтгэл



хоёрыг харьцуулсан ч зөрүүг тайлбарлаагүй байв. Өөрөөр хэлбэл, олон нийтэд ил болгосон жилийн гүйцэтгэлийн тайланд ордог мэдээ, мэдээлэл аймаг бүрээр харилцан адилгүй байлаа.

Орон нутгийн төсвийн гүйцэтгэлд төрийн аудитын байгууллагаас хөндлөнгийн хяналт тавьдаг ба энэ нь төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулсан эсэхэд хяналт тавьдаг мэргэжлийн хамгийн чухал институци юм. Аудит өндөр түвшинд хийгдсэн, түүний тайлан бүрэн дүүрэн, олон нийтэд нээлттэй байх ёстой. Харамсалтай нь найман аймагт орон нутгийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг олон нийтэд огт танилцуулдаггүй байна. Харин Баянхонгор, Завхан, Төв, Ховд зэрэг аймгуудад аудитын олон нийтэд иж бүрнээр танилцуулсан байхад өөр 10 аймагт тайлангийн зөвхөн хураангуй дүнг олон нийтэд хүргэдэг байна. Цаашилбал, аудитын байгууллагын зүгээс олж тогтоосон зөрчил, дутагдлын дагуу авсан арга хэмжээний тухай орон нутгийн засаг захиргааны зүгээс олон нийтэд тайлагнадаггүй нийтлэг дүр төрх ажиглагдав. Энэ тухай Завхан аймагт л олон нийтэд хүргэсэн ба зөвхөн орон нутгийн ИТХ, мөн аудитын газарт хүргүүлдэг 11 аймаг байхад найман аймагт аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу арга хэмжээ авдаг ч олон нийтэд тайлагнадаггүй, харин дөрвөн аймагт ямар нэгэн арга хэмжээ авсан тухай мэдээлэл алга байна. Өөрөөр хэлбэл, төсвийн зарцуулалтын үр дүн болон хариуцлага тооцогдож байгаа эсэх талаар иргэд хяналт тавих нөхцөл орон нутгийн түвшинд бүрэлдээгүй байна.

### ***Орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах ажиллагаа***

Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, тендер шалгаруулалтын үйл явц нь төсвийн зарцуулалтанд онцгой байр суурийг эзэлдэг ба их хөрөнгө мөнгөтэй холбоотой, мөн санхүүжүүлсэн төслүүд нь орон нутгийн иргэдийн аж амьдралд үлэмж нөлөө үзүүлэх боломжтой тул иргэд ийм санхүүжилт хэнд очих болон зарцуулалтын явц, үр дүнгийн талаар бүрэн, цаг алдаагүй мэдээлэлийг байсан цагт хяналт тавьж чадна. Тиймээс уг судалгаанд худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал орон нутгийн түвшинд хэрхэн хэрэгждэг талаар дөрвөн асуулт тусгайлан оруулсан юм.

Тендер шалгаруулалтыг хэрхэн явуулах талаарх нийтлэг журмуудын тухай мэдээллийг олон нийтэд ил дэлгэсэн 10 аймаг, иргэд хүсэлт гаргасан тохиолдолд уг мэдээллийг ил болгодог гурван аймаг байхад зөвхөн уг тендер оролцогчдод зориулан нийтлэг журмуудаа танилцуулдаг таван аймаг, ийм мэдээллийг иргэдэд огт танилцуулдаггүй дөрвөн аймаг (Баянхонгор, Дархан-Уул, Дундговь, Хэнтий) байв. Ер нь тендерийн ерөнхий журмууд болон

тендерийн зар мэдээллийн талаар орон нутгийн холбогдох албан тушаалтнууд тусгайлан ялгадаггүй байдал ажиглагдсаныг тэмдэглэх хэрэгтэй. Тодорхой тендерийн зарыг материал хүлээж авахаас нэг сарын өмнө нийтэд зарладаг аймаг 17 байхад Булган, Хөвсгөл гэх хоёр аймагт зарыг хоёр долоо хоногийн өмнө түгээсэн жишээ байгаа нь тухайн тендерийн талаархи мэдээллийг компаниуд цаг алдалгүй авч бэлтгэлээ ханган оролцоход хангалттай хугацаа гэдэгт эргэлзээ төрүүлж байна Гэхдээ уг асуудал хуулийн дагуу зохицуулагдах нв ойлгомжтой. Өөр гурван аймагт (Архангай, Дорнод, Дундговь) холбогдох албан тушаалтнууд тендерийн зарын хугацаатай холбоотой мэдээлэл, нотлох баримтыг гаргаж өгөөгүй байна.

Орон нутгийн тендер шалгаруулалтын явц иргэдэд нээлттэй биш байна. Тухайлбал, Сүхбаатар, Сэлэнгэ аймгуудад тендер шалгаруулах хорооны бүрэлдэхүүнийг олон нийтэд ил болгодог, мөн өөр таван аймагт ийм мэдээллийг зөвхөн иргэд шаардсан үед шалгаруулалтын дараа танилцуулдаг бол бусад бүх аймагт энэхүү хорооны бүрэлдэхүүн нийтэд хаалттай байлаа. Тендерт оролцсон болон шалгарсан компаниудын талаарх мэдээллийг Завхан, Сэлэнгэ аймагт ил зарладаг бол Дундговь аймагт тендерийн тухай ямар нэгэн мэдээллийг олон нийтэд хүргэдэггүй, мөн өөр зургаан аймагт тендерийн холбогдолтой зарим нэгэн мэдээллийг ил болгодог ч оролцсон болон шалгарсан компаниудын тухай мэдээлэл байхгүй, харин 13 аймагт тендерт шалгарсан компаниудын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэсэн ч тэдэнтэй өрсөлдөн ялагдсан компаниудын тухай мэдээлэл алга байлаа.

### ***Төсвийн үйл явцын нээлттэй байдал***

Хүснэгт 9-т танилцуулсан оноонуудыг харахад төсвийн үйл явцын ил тод байдалтай холбоотой асуултуудад аймгуудын авсан онооны дундаж нь 38.1 байгаа нь бусад хэсгүүдийн онооноос харьцангуй өндөр ч нийт авч болох 100 оноотой харьцуулахад чамлайхуйц дүн юм. Нийт 12 асуултаас бүрдсэн уг хэсгийн хариултуудыг задлан шинжилбэл дараах дүр зураг харагдаж байна. Төсвийн хамгийн чухал баримт бичгийн нэг болох төсвийн төслийг Засаг даргын зүгээс ИТХ-д өргөн барихаас өмнө олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан аймаг ганцхан Завхан байв. Харин аль ч аймагт ИТХ-аас ямар нэгэн олон нийтийн хэлэлцүүлэг, сонсгол хийдэггүй байна. Өөрөөр хэлбэл, төсвийг төлөвлөх болон батлах үе шатанд олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг орон нутгийн төр захиргааны зүгээс огт авч хэрэгжүүлдэггүй байна. Түүнчлэн 15 аймагт төсөвтэй асуудлаар иргэдээс бичгээр санал авдаггүй, зарим аймагт зөвхөн сумд, холбогдох төсвийн байгууллагуудаас л санал авдаг байна. Үүнийгээ зарим аймгуудад иргэдийн оролцоо, сонирхол муу байдагтай холбон

тайлбарласан нь өөрсдийгөө зөвтгөсөн өрөөсгөл хандлага гэж үзэж байна.

Харин төсвийн төслийг хэлэлцэн баталдаг орон нутгийн ИТХ-ын ээлжит хуралдааныг (жил бүрийн 12-р сарын сүүлчээр болдог) харьцангуй нээлттэй явуулдаг болж байгаа нь сайшаалтай. Тухайлбал, 11 аймагт хуралдааныг орон нутгийн радио, телевизээр шууд дамжуулсан, хоёр аймагт хуралдааны танхимд иргэд орж ажиллахад саад учраагүй, мөн найман аймагт иргэд зөвшөөрөл авч ИТХ-д суусан байна. Харин Увс аймагт иргэд хуралдаанд оролцох эрх нээлттэй ч бодит нөхцөл байдлаас болж оролцох боломж нь хязгаарлагдмал байжээ. Мөн 17 аймагт төсвийн хэлэлцүүлгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд иж бүрэн, дэлгэрэнгүй мэдээлсэн бол бусад аймгуудад хөрөнгө мөнгө зэрэг шалтгаанаар товчхон мэдээлэл хүргэжээ. Сэлэнгэ аймагт ИТХ нь, Улаанбаатар хотод Засаг даргын зүгээс ирэх оны батлагдсан төсвийн талаар сэтгүүлчдэд зориулж тусгайлан хэвлэлийн хурал хийсэн нь бусад аймгуудад ч хэрэгжүүлэх бүрэн боломжтой сайн туршлага юм.

Иргэдэд төсвийн тухай мэдээлэл хүргэж болох бусад сувгуудын талаар судалгааны хүрээнд бас авч үзлээ. Тухайлбал, аймгийн төр захиргааны байран дахь мэдээллийн самбарт төсвийн тухай мэдээллийг байршуулдаг эсэхийг лавлахад долоон аймагт иж бүрэн, цэгцтэй, иргэд ойлгохуйц мэдээллийг байршуулсан, харин хоёр аймагт төсвийн тухай мэдээлэл тавьсан ч иргэд үзэх боломж хязгаарлагдмал, тухайлбал хурлын танхим зэрэг газар байршуулсан бол үлдсэн 13 аймагт мэдээллийн самбарыг төсвийн мэдээллийг нийтэд хүргэх зорилгоор ашиглаагүй байна. Аймаг бүрт байдаг нийтийн номын санд сүүлийн үеийн төсвийн мэдээллийг байршуулсан нь ганц Дорнод аймаг байсан бол хугацааны хувьд хожимдсон мэдээллийг Говьсүмбэр аймгийн номын сангаас авч байв. Бусад аймгууд ийм мэдээллийг номын санд тавьдаггүй, харин Төв зэрэг цөөн хэдэн аймагт нилээд хэдэн жилийн өмнөх мэдээлэл байлаа. Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ, Ховд зэрэг аймгуудад төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор нээлттэй өдөрлөг, уулзалт ярилцлага зэргийг зохион байгуулсан бол өөр есөн аймагт ийм арга хэмжээг төрийн бусад үйл ажиллагааны хүрээнд хамруулан явуулж, төсвийн мэдээлэл, үйл явцыг нээлттэй танилцуулж байжээ. Цаашдаа бусад есөн аймагт ч иймэрхүү арга хэмжээг шинээр, улмаар бүх аймгууд тогтмол явуулж байх эхлэл тавигдсан байна.

Сүүлийн жилүүдэд “УИХ-ын гишүүний мөнгө” хэмээх ойлголт бий болж, орон нутгийн хувьд багагүй хэмжээний хөрөнгө оруулалтыг тухайн аймаг, нийслэлийн дүүргээс сонгогдсон УИХ-ын гишүүний бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу хуваарилан зарцуулж байгаа билээ. Гэтэл УИХ-ын гишүүд уг хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар сонсогчдынхоо саналыг сонсож, явц, үр дүнг нь олон нийтэд тайлагнах явдал хангалтгүй байна. Тухайлбал, найман аймагт энэ асуудлаар уулзалт хэлэлцүүлгийг огт зохион байгуулаагүй

бол долоон аймагт зөвхөн зарим нэгэн гишүүн л ийм уулзалтуудыг зохион байгуулж, зөвхөн үлдсэн долоон аймагт тухайн тойргоос сонгогдсон бүх гишүүд ийм мэдээллийг иргэдтэй уулзах үеэрээ солилцдог байна. Харин гишүүд орон нутгийн засаг захиргаатай тухайн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар илүүтэй ярилцдаг байна. Тодруулбал, 16 аймагт тухайн тойргоос сонгогдсон бүх гишүүд энэ асуудлаар албан ёсоор зөвшилцсөн бол өөр хоёр аймагт зарим нэгэн гишүүд ийм ажлыг зохион байгуулжээ. Харин Сэлэнгэ аймаг, мөн Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүд орон нутгийн удирдлагуудтай тэр бүр ажлаа зохицуулан төлөвлөөгүй байна.

Эцэст нь нийт 19 аймаг вэб хуудастай ч зөвхөн Улаанбаатар, Сэлэнгэ аймгуудад л төсвийн тухай иж бүрэн, сүүлийн үеийн мэдээллийг тус вэб хуудсандаа байршуулсан байгаа нь хангалтгүй юм. Есөн аймгийн вэб хуудсанд төсөвтэй холбоотой цөөн тооны, эсвэл хуучирсан мэдээллийг байршуулсан байсан бол найман аймаг вэб хуудастай ч түүндээ төсвийн мэдээлэл тавиагүй байв. Цаашилбал, Дундговь, Увс, мөн ялангуяа Орхон аймагт вэб хуудас байхгүй, эсвэл удаан хугацаагаар ажиллахгүй байсныг хэлэх хэрэгтэй. Цаашид вэб хуудсаар дамжуулан төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх шаардлага улам бүр нэмэгдэж байгаа нь судалгааны явцад харагдсан ба аймгуудаас олж авч чадахгүй төсөвтэй холбоотой олон мэдээллийг төвийн, тухайлбал Сангийн яамны болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын вэб хуудаснаас авч байсныг энд дурьдах нь зүйтэй.

# 5

## Бодлогын зөвлөмж

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсад орон нутгийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал ямар түвшинд байгаад хөндлөнгийн үнэлэлт өгч, улмаар орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын үйл явцад ил тод, нээлттэй байдлыг хэвшүүлэх бодлогод нөлөөлөх явдал юм. Ялангуяа аймаг, нийслэлийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын хувьд уг судалгаа нь орон нутгийн түвшинд ил тод, хариуцлагатай төсвийн зарцуулалтыг шаардах суурь мэдээлэл болно гэдэгт итгэж байна.

Энэхүү судалгааны үр дүнд дараах хэд хэдэн бодлогын зөвлөмжийг гаргаж байна.<sup>1</sup>

- Төсвийн ил тод ба нээлттэй байдал орон нутгийн түвшинд туйлын хангалтгүй хэмжээнд байна. Судалгааны дүнгээр аймгууд, нийслэлийг авсан оноогоор нь байр эзлүүлэн жагсаахад хамгийн их нөлөөлсөн хүчин зүйл нь тухайн аймгийн удирдлагын арга барил, ил тод, нээлттэй байдалд хандах хандлага болохоос биш, зардал мөнгө зэрэг хүчин зүйл биш нь тодорхой харагдаж байна. Тиймээс орон нутгийн засаг захиргаа төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх, төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгох явдлыг байнгын зорилт, өдөр тутмын ажлын соёл, үйл ажиллагааны үр дүнг хэмжих шалгуур болгон хэвшүүлэх шаардлагатай байна.
- Орон нутгийн засаг захиргаа төсвийн мэдээллийг ил тод нээлттэй болгож иргэдийн оролцоог хангахдаа дээрээс хууль, тогтоол, шийдвэр хүлээхээс илүү өөрсдийн эрх мэдэл, боломжинд тулгуурлах нь зүйтэй. Юуны өмнө тухайн орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хувьд Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас энэ асуудлаар албан ёсны тогтоол шийдвэр гаргаж нутаг дэвсгэртээ дагаж мөрдүүлэх эрх зүйн маш чухал боломж байгаад анхаарлаа хандуулах цаг болжээ.
- Орон нутгийн иргэдэд хүртээмжтэй энгийн арга, хэрэгслийг өргөнөөр ашиглах нь зүйтэй. Ялангуяа уг судалгаанд онцлон авч үзсэн төсөвтэй холбоотой арван гол баримт бичгийг цахим хуудас, орон нутгийн сонин, радио телевизээр танилцуулахаас гадна номын сан, янз бүрийн мэдээллийн самбар зэрэг иргэдэд дөхөм хэлбэрүүдээр хүргэх хэрэгтэй.
- Төсвийн баримт бичгүүдийг батлагдахаас нь өмнө төсөл хэлбэрээр олон нийтэд хүргэж, сонирхсон иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын

<sup>1</sup> Эдгээр зөвлөмж нь судлаачдын өөрсдийн байр суурийг илэрхийлэх ба тэдний ажилладаг байгууллагуудын байр суурь биш байж болно.

зүгээс санал бодлоо илэрхийлэх, хэлэлцүүлэг өрнүүлэх нөхцлийг бүрдүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэй.

- Орон нутгийн төр, захиргааны байгууллагууд харилцан туршлага солилцох, бусад аймаг, нийслэлээс суралцах шаардлагатай байна. Уг судалгаанд хамрагдсан аймгуудын ил тод, нээлттэй байдлын ерөнхий түвшин хангалтгүй байгаа ч аймгууд хоорондоо ихээхэн ялгаатай дүн үзүүлжээ. Зарим аймагт олон нийтэд мэдээлэл хүргэхэд хэрэглээд хэвшчихсэн аргуудыг бусад аймагт огт ашигладаггүй жишээ олон байна. Үүнд хэвлэлийн хурал, олон нийтийн сонсгол гэх мэт олон аргуудыг ихэнх аймаг ашиглахгүй байна.
- Орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагууд төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах үйл явцад одоогийнхоос хавьгүй илүү идэвх, санаачлага гарган оролцох ёстой. Үүнд, төсвийн мэдээллийг албан сувгуудаар хүсэлт тавин гаргуулж авах, олон нийтэд тайлбарлан хүргэх, судалгаа шинжилгээ явуулах, зарцуулалтанд хяналт тавих зэрэг олон боломжийг бүрэн гүйцэд ашиглахгүй байна. Орон нутагт ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд энэ ажлыг манлайлах бүрэн боломжтой. Эцсийн дүндээ төсвийн ил тод байдлыг хянах, төсвийн гүйцэтгэлийн үр дүнг мэдрэх, төсвийн үйл явцад оролцох бололцоо гагцхүү орон нутгийн иргэдэд л бий гэдгийг санах шаардлагатай.
- Засгийн газар ба хяналтын байгууллагуудын зүгээс орон нутгийн төсвийн үйл явцыг илүү боловсронгуй болгон журамлаж нэгэн жигд стандартыг боловсруулан мөрдүүлэх шаардлага гарч байна. Үүнд, орон нутгийн төсвийн мэдээллийн чанар, иж бүрэн байдал, цаг хугацааны болон бусад шаардлагууд ч хамаарна.
- УИХ-аас Төсвийн хуулийг шинэчлэн батлахдаа төсвийн мэдээлэл ба төсвийн үйл явцыг илүү нээлттэй болгох талаар урьдынх шиг ерөнхий биш, маш тодорхой заалтуудыг хуулинд тусган оруулах шаардлагатай байна. Төсвийн үйл явцад иргэдийг оролцуулах явдлыг ялангуяа төсвийн төлөвлөлтийн үе шатанд заавал хангах эрх зүйн тодорхой шаардлагуудыг элдэв журам, дүрэм бус, хуулийн түвшинд тавих нь онцгой ач холбогдолтой. Төрийн байгууллагууд хоорондоо төсвийн мэдээллийг албан ёсоор хүргүүлэх, өргөн барихдаа олон нийтэд зэрэг хүргэдэг механизмыг төрийн ажлын соёлын нэг хэсэг болгох боломж байна.

- Төсвийн төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэн, орон нутагт илүү эрх мэдэл олгохын зэрэгцээ хариуцлагыг нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэх үүргийг хуулиар хүлээлгэх шаардлага тулгарч байгааг судалгааны үр дүн харуулж байна. Орон нутгийн төсвийн эрх мэдэл нэмэгдсэнээр иргэдийн зүгээс хяналт тавих сонирхол ч нэмэгдэх хандлагатайг бодолцон орон нутгийн иргэд, төр захиргааны байгууллагуудын харилцааг ил тод, нээлттэй, өгөөжтэй болгож, хэн нэгэн даргын хандлагаас бага хамаарах нөхцлийг бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

# 6

## Хавсралтууд

### 6.1. Арга зүй

Энэ хэсэгт орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын судалгааг хийхэд ашигласан арга зүйг тайлбарлах болно. Судалгааны зорилго нь орон нутгийн буюу аймаг, нийслэлийн түвшинд төсвийн мэдээллийн болон үйл явцын ил тод, нээлттэй байдалд үнэлгээ өгөх явдал юм. Судалгааны аргачлал нь төсвийн ил тод, нээлттэй байдлын хууль зүйн шаардлагуудыг үнэлэхээс гадна бодит байдалд мэдээллийн ил тод байдал, үйл явцын нээлттэй байдал ямар байгааг мөн үнэлэх юм.

Энэхүү судалгаа нь төсвийн хөрөнгийн зарцуулалтын чанар, үр ашигтай байдлыг үнэлэхгүйг анхаарна уу. Харин ил тод, нээлттэй байдлын үндсэн дээр иргэд орон нутгийн албан тушаалтнуудаас төсвийн гүйцэтгэлийн чанар, үр ашгийн талаар асуух, шаардлага тавих боломжийг хангасан механизмууд байгаа эсэхийг тодорхойлох зорилготой.

#### ***Нээлттэй төсвийн индексийн аргачлалыг тохируулан ашиглав***

Уг судалгааны ерөнхий аргачлал нь Олон улсын төсвийн түншлэл (*International Budget Partnership*)<sup>2</sup> байгууллагын Нээлттэй төсвийн индекс судалгааны арга зүй дээр үндэслэсэн ба аймгуудыг эрэмбэлэн жагсаахад ашигласан оноонууд ч дээрх судалгааныхтай төстэй юм. Аймгууд дахь төсвийн ил тод, нээлттэй байдлыг үнэлэхэд ашигласан гол хэрэгсэл бол төсвийн чансааг тодорхойлох асуулга юм. Уг асуулгад авсан оноогоор нь аймгууд, нийслэлийг эрэмбэлсэн билээ. Судалгааг орон нутагт байнга оршин суудаг, бие даасан нэг судлаач бөглөж, ахлах судлаачаар хянуулсан ба асуулгын хариултыг сонгох үндэслэл болсон холбогдох нотлох баримтуудыг цуглуулсан байгаа. Судлаачид албан тушаалтнуудаас ярилцлага авах, төсвийн баримт бичигтэй танилцах, эрх зүйн болон бусад холбогдох мэдээллийг судлах, ажиглалт явуулах зэрэг замаар мэдээллээ бүрдүүлсэн болно.

<sup>2</sup> Нээлттэй төсвийн индексийн талаар [www.openbudgetindex.org](http://www.openbudgetindex.org) вэб хуудаснаас нэмэлт мэдээлэл авах боломжтой.



### **Асуулга**

Судалгааны үндсэн асуулга нь хоёр хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Судалгаанд ашигласан төсвийн баримт бичгийн жагсаалт, тэдгээрийн олон нийтэд ил эсэхийг үнэлсэн хоёр хүснэгт;
- Төсвийн баримт бичиг, үйл явцын ил тод, нээлттэй байдлын эрх зүйн орчин, төсвийн мэдээллийн хүртээмж ба иж бүрэн байдал, төсвийн үйл явцын нээлттэй байдал гэсэн гурван хэсэг бүхий 60 асуулттай анкет зэрэг орно.

Хүснэгт 1-д судлаачид тухайн судалгааны асуулгыг бөглөхөд ашигласан баримт бичгийг жагсааж, тэдгээрийн албан нэр, нийтэд ил болгосон огноо, хамрах төсвийн жил, мөн интернэт дээр байгаа бол байршуулсан холбоосын хаягийг тэмдэглэсэн. Судалгааны зорилгын хувьд зөвхөн олон нийтэд ил мэдээллийг ашиглан үнэлгээ хийсэн болно. Өөрөөр хэлбэл, тухайн төсвийн баримт бичиг вэб хуудаснаа байгаа, эсвэл жирийн иргэн хүсэлт гарган авч болох баримт бичиг дээр үндэслэн үнэлгээг хийсэн болно. Судалгааны асуулгыг бөглөхөд аймаг тус бүрт, мөн нийслэлд нийт 16 баримт бичгийг судлан үзсэн ба үүнээс 10 баримт бичгийн ил тод байдлыг тусгайлан судлаж, оноо өгсөн билээ.

Хүснэгт 2-нь өөрөө хоёр хэсэгтэй. Эхний хэсэгт төсвийн дээрх 10 гол баримт бичиг олон нийтэд ил байгаа эсэхийг үнэлсэн. Хоёрдугаар хэсэгт эдгээр баримт бичгийг ил болгож буй сувгууд, тухайлбал интернэт, номын сан зэргийн талаар мэдээллийг, мөн тухайн баримт бичгийг цаг хугацааны хувьд шуурхай ил тод болгож байгаа эсэхийг үнэлэх юм. Дээр дурьдсан төсвийн 10 гол баримт бичигт дараахь баримтууд орсон байгаа:

- 1) Төсвийн хүрээний мэдэгдэл
- 2) Үйл ажиллагааны төлөвлөгөө ба төсвийн санал
- 3) Төсвийн төсөл
- 4) Батлагдсан төсөв
- 5) Хураангуй төсөв
- 6) Төсвийн тодотгол
- 7) Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 8) Улирал тутмын төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 9) Жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 10) Аудитын тайлан

Энэхүү хоёр хүснэгт нь хамтдаа орон нутгийн зүгээс төсвийн холбогдолтойгоор гаргадаг баримт бичгүүдийг тоймлон судлаж, олон нийтэд

ил байгаа эсэхийг тодорхойлж, мөн мэдээллийг ил болгож буй арга, хэлбэрийг шинжилж байгаа.

Асуулгын хоёрдугаар хэсэг болох олон сонголттой хариулт бүхий 60 асуулт нь дээрх хоёр хүснэгтэнд орсон мэдээллийг дэлгэрүүлэн, нарийвчлан судлах зорилготой ба төсвийн мэдээллийг ил болгох эрх зүйн орчин, ил байгаа мэдээллийн чанар, хүртээмж, мөн мэдээллийг ил болгох, иргэдийн төсвийн үйл явцад оролцуулах арга, механизмуудын талаар судлах зорилготой. Судлаач 3-6 хариултаас аль нэгийг нь (цөөн асуултын хувьд давхар хариулт сонгох боломжтой) сонгож хариулсан. Асуултыг хариулахдаа судлаач холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, төсвийн баримт бичигтэй танилцах, судлах зэргээр нотолгоог бүрдүүлсэн. Судалгааны асуултууд эцсийн оноог тооцоход бүгд ижил хувийн жинтэй. Хариулт 1 нь хамгийн боломжийн оноотой байх бол сүүлийн хариултууд ил тод бус, нээлттэй бус байдлыг илтгэнэ.

Асуулгын 60 асуулт нь гурван бүлэгт хуваагдах ба эдгээр нь:

- 1) Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг зохицуулах эрх зүйн орчин (1-11-р асуултууд);
- 2) Орон нутгийн төсвийн мэдээллийн хүртээмж, иж бүрэн байдал (12-48-р асуулт);
- 3) Төсвийн үйл явцын ил тод байдал (49-60-р асуулт).

Эхний хэсэгт орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал болон гүйцэтгэх засаглалын зүгээс төсвийн мэдээллийг олон нийтэд ил тайлагнаж, иргэдийг төсвийн үйл явцад татан оролцуулах талаар ямар нэгэн захирамж, шийдвэр, эрх зүйн зохицуулалт байдаг эсэхийг тодорхойлох зорилготой. Үүнд холбогдох албан тушаалтнуудын бүтээгдэхүүн нийлүүлэх болон үр дүнгийн гэрээ, орон нутгийн засаг захиргааны мөрийн хөтөлбөр зэрэг бодлогын гол баримт бичгүүдэд энэ талаар тодорхой заалтууд ордог эсэх, мөн хэрэв тийм бол хэрэгжилт, үр дүнг нь хэлэлцэж, олон нийтэд хүргэдэг эсэхийг тодорхойлохыг мөн оролдож байгаа.

Хоёрдугаар хэсэг хамгийн олон асуулттай (37) бөгөөд нийт судалгааны үр дүнд хамгийн их жинтэй юм. Энэ хэсэгт орон нутгийн төсвийн гол баримт бичиг болох төсвийн санал, төсвийн төсөл, төсвийн тайлан, аудитын тайлан зэрэг хэд хэдэн баримт бичиг ИТХ болон олон нийтэд хүрч байгаа байдал, эдгээр баримт бичгийн агуулга нь иргэдэд ойлгомжтой мэдээлэл өгөхүйц түвшинд байгаа эсэхийг үнэлэх зорилготой. Мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа хэлбэр, хэмжээ, цаг хугацааг онцгойлон анхаарсан болно. Түүнчлэн олны анхаарлыг ихээхэн татдаг, мөн төсвийн зарцуулалтын үр дүнд чухал үүрэгтэй хөрөнгө

оруулалтын төслүүдийн санхүүжилттэй гол төлөв холбоотой явагддаг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа болон тендер шалгаруулалтын талаар тусгайлан асуултууд оруулсан болно.

Асуулгын гуравдугаар хэсэгт орон нутгийн иргэд төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын үе шатуудад санал бодлоо илэрхийлэн ИТХ болон Засаг даргын шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтойгоор оролцох орон зай байгаа эсэх талаарх бодит байдлыг судлахыг зорив. Мөн вэб хуудас, номын сан, мэдээллийн самбар, хурал зөвлөгөөн, сонсгол зэрэг олон хэлбэрийг орон нутгийн засаг захиргаа ашиглан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж байгааг ашигладаг байдлыг судласан болно.

### ***Оноог тооцсон нь***

Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлаар аймгуудыг жагсаахад тус судалгааны хариулт тус бүрт тодорхой оноо ногдуулж, түүний дундаж дүнгээр аймгуудыг эрэмбэлсэн билээ. Ингэхдээ судалгааны эхний хэсэг болох хоёр хүснэгтийн мэдээлэлд үндэслэн Оноо I-г бүрдүүлсэн ба сүүлийн хэсэг буюу 60 асуултын хариултын дүнг үндэслэж Оноо II-г бүрдүүлсэн. Оноо I-г тооцоход тухайн төсвийн баримт бичгийг олон нийт чөлөөтэй, цаг хугацаанд нь авч болохоор бол (интернэт, номын сан, мэдээллийн төв, мэдээллийн самбар, үнэгүй хувь г.м.) 100 оноо, харин тухайн баримт бичгийг зөвхөн хүсэлт гарган авах боломжтой бол 50 оноо, харин тухайн баримт бичгийг зөвхөн албан хэрэгцээнд зориулан боловсруулдаг болон огт гаргадаггүй бол тэг оноо өгсөн болно. Оноо I нь ил тод байдлын эцсийн чансааг тогтооход 30 хувийн жинтэй болно. Өөрөөр хэлбэл, асуулгын хоёрдугаар хэсэг буюу 60 асуултын хариултын дүнгээр Оноо II-г бүрдүүлсэн ба энэ нь 70 хувийн жинтэй болно.

Оноо II-ын хувьд асуулгын хоёрдугаар хэсэг болох 60 асуултанд авсан онооны дундаж дүн юм. Тодруулбал, ил тод, нээлттэй байдлыг хамгийн ихээр илэрхийлж буй хариултанд 100 оноо, дараачийн эерэг хариултанд 66 оноо, түүний дараачийн эерэг хариултанд 33 оноо өгсөн бол төсвийн ил тод, нээлттэй байдал хангалтгүй ч холбогдох баримт бичиг ил тод байсан бол 10 оноо, харин баримт бичиг ч ил бус бол тэг оноо өгсөн болно.

### ***Судалгааны чанарыг баталгаажуулах нь***

Судалгааны хүрээнд цуглуулсан мэдээлэл бодитой, үнэн зөв байж үр дүн бодитой, чанартай гарах тул судалгааны чанарыг баталгаажуулах хэд хэдэн аргыг хэрэглэсэн болно. Тухайлбал, судалгааны асуулгыг туршилтын журмаар

бөглөсөн, Олон улсын төсвийн түншлэл байгууллагын болон дотоодын зөвлөхүүдийн санал дүгнэлтийг судалгааны аргачлал, асуулгыг боловсруулахад авсан, судлаачдыг удирдамжаар хангасан, ахлах судлаачдыг ажиллуулсан зэрэг алхмуудыг хэрэгжүүлсэн болно. Судалгааны асуулгыг Төв аймагт туршин үзсэн ба анх 40 асуулттайгаар бэлтгэсэн асуулгыг уг туршилтын дүнгээр 60 болгон өргөтгөсөн ба асуулгын бүтэц, асуултуудын дэс дарааг ихээхэн өөрчилсөн болно. Бусад улс орны туршлагаас судлах зорилгоор Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачлагын мэргэжилтнүүдээс санал авч, эцсийн асуулгыг боловсруулахад мөн тусгасан билээ.

Судлаачдыг сонгоход онцгой анхаарсан болно. “Иргэд төсвөө хянана” сүлжээний гишүүн, бие даасан иргэний нийгмийн дөрвөн байгууллагын төлөөлөгчдийг ахлах судлаачдаар урьж ажиллуулсан. Тэд тус бүрдээ 5-6 аймгуудыг хариуцан, орон нутаг дахь судлаачидтай нягт холбоотой ажилласан билээ. 21 аймаг бүрт, мөн Улаанбаатар хотод тус бүрт нь судлаач ажиллуулсан.<sup>3</sup> Эдгээр судлаачид бүгд төрийн байгууллагатай холбоогүй, гол төлөв иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл байсныг онцлох хэрэгтэй. Бүх асуултын хувьд судлаачид тодорхой хариулт сонгох болсон үндэслэл, тухайлбал мэдээллийн эх сурвалж, ишлэл зэргийг нарийвчлан тусгаж, төсвийн баримт бичиг, мэдээллийн хувийг цуглуулсан болно. Мөн хариултаа сонгохдоо аль болох олон эх сурвалжийг үндэслэхийг судлаачид эрмэлзсэнийг тэмдэглэж байна.

<sup>3</sup> Судлаачдын нэрсийг Хавсралт 6.5-аас үзнэ үү.

## 6.2. Асуулга

Орон нутгийн төсвийн ил тод байдлын индексийг гаргахад ашигласан асуулгыг танилцуулж байна.

### *Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс-2011*

#### *Судалгааны асуулга*

2011 оны 1-р сар

---

#### **Судалгааг зохион байгуулагчид:**

- Нээлттэй Нийгэм Форум
- “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ
- Олон улсын төсвийн хамтын ажиллагаа байгууллага

Аймаг: .....
Судлаач:.....
Холбогдох хаяг:.....
Ахлах судлаач:.....
Холбогдох хаяг:.....

### ***Орон нутгийн төсвийн үйл явцтай холбоотой төсвийн баримт бичгүүд, тэдгээрийн ил тод, нээлттэй байдал***

#### **Хүснэгт 1. Судалгаанд ашигласан төсвийн үйл явцтай холбоотой баримт бичгүүд**

Энэ нь орон нутгийн төсвийн ил тод байдлын индексийг тооцох асуулгыг бөглөхөд ашиглах шаардлагатай төсвийн баримт бичгүүд юм. Тухайн баримт бичиг төсвийн ямар жилд хамаатай болох, уг баримт бичгийн нэр, огноо, вэб сайт дээрх байршлыг энэ хүснэгтэд тэмдэглэнэ. Судалгаа хийх үед эцэслэн гарсан байсан хамгийн шинэ баримт бичгийг ашиглах шаардлагатай.

№	Баримт бичгийн нэр	Хамравал зохих төсвийн жил	Судалгаанд хамарсан төсвийн жил	Баримт бичгийн албан ёсны нэр, огноо, вэб холбоос
1	Төсвийн хүрээний санал	2011		
2	Үйл ажиллагааны төлөвлөгөө буюу төсвийн санал	2011		
3	Төсвийн төсөл	2011		
4	Батлагдсан төсөв	2011		
5	Хураангуй (иргэдэд зориулсан) төсөв	2010		
6	Төсвийн тодотгол	2010		
7	Сар тутмын тайлан	2010		
8	Улрал тутмын тайлан	2010		
9	Жилийн эцсийн тайлан	2009		
10	Аудитын тайлан	2009		
11	Засаг даргын мөрийн хөтөлбөр	2008-12		
12	Засаг даргын ИТХ-тай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ	2010		
13	Боловсролын газрын төсвийн ерөнхий менежерийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээ	2010		
14	Эрүүл мэндийн газрын төсвийн ерөнхий менежерийн Засаг даргатай байгуулах үр дүнгийн гэрээ	2010		
15	Засаг даргын Тамгын газрын даргын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ	2010		
16	Санхүүгийн асуудал эрхэлсэн хэлтсийн даргын Засаг даргын Тамгын газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ	2010		

## Хүснэгт 2. Төсвийн баримт бичгийн ил тод, нээлттэй байдал

Хүснэгтийн энэ хэсэгт зөвхөн “Тийм” гэдэг хариултыг зохих нүдэнд бичнэ.	Төсвийн хүрээ	Төсвийн санал	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Хураангуй төсөв	Төсвийн тодотгол	Сар бүрийн тайлан	Улирал тутмын тайлан	Жилийн тайлан	Аудитын тайлан
Огт боловсруулдаггүй	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Зөвхөн албан хэрэгцээнд зориулан боловсруулдаг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Боловсруулдаг ба иргэд хүсэлт гарган авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Боловсруулдаг ба иргэдэд үнэгүй хэлбэрээр нээлттэй хүрдэг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Хүснэгтийн энэ хэсэгт “Тийм” эсвэл “Үгүй” хариултыг сонгон бичнэ	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Интернэт дээр бүрэн эхээрээ байдаг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Аймгийн номын санд дэлгэсэн байдаг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Интернэт мэдээллийн төвд дэлгэсэн байдаг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Үнэгүйгээр хэвлэмэл хувийг авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Албан бичгээр хүсэлт тавьж авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Таргасан байгууллагаас нь авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Баримт бичиг гарсан өдрөөс долоо хоногийн дотор авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Баримт бичиг гарсан өдрөөс нэг сарын дотор авч болдог	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Баримт бичиг гарсан өдрөөс	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Мэдээллийн самбарт байрлуулдаг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----
Хэвлэлийн хурал зарлаж олон нийтэд мэдээлдэг	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----	-----

**Нэгдүгээр хэсэг. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ  
ИЛ ТОД БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГУУД**

Асуулт 1. Тус орон нутгийн төсвийн баримт бичгийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар ИТХ-аас гаргасан шийдвэр, эрх зүйн аливаа баримт бичиг байна уу?

1. Тийм (А-ыг хариулна уу)
  - 1.1. ИТХ-ын тогтоол
  - 1.2. Бусад \_\_\_\_\_
2. Үгүй (Асуулт 3-ыг хариулна уу)
3. Аль нь ч биш буюу өөр бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 2. Асуулт 1-д дурьдагдсан ИТХ-ын шийдвэр, баримт бичгийн хэрэгжилтийг ИТХ-аас тайлагнаж дүгнэдэг үү?

1. Тийм, ИТХ-аас тайлагнаж дүгнэдэг ба сайн дүнтэй гарсан
2. Тийм, ИТХ-аас тайлагнаж дүгнэдэг ба хангалтгүй дүнтэй гарсан
3. Дүгнэдэггүй
4. Аль нь ч биш буюу өөр бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....



Асуулт 3. Орон нутгийн төсвийн баримт бичгийн ил тод, нээлттэй байдлыг хангах талаар Засаг даргын гаргасан шийдвэр, эрх зүйн аливаа баримт бичиг байна уу?

1. Тийм
  - 1.1. Засаг даргын захирамж
  - 1.2. Бусад\_\_\_\_\_
2. Үгүй
3. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 4. Асуулт 3-т дурьдагдсан Засаг даргын шийдвэр, баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнаж дүгнэдэг үү?

1. Тийм, Засаг даргын шийдвэрийг тайлагнаж дүгнэдэг ба сайн дүнтэй гарсан
2. Тийм, Засаг даргын шийдвэрийг тайлагнаж дүгнэдэг ба үнэлгээ нь хангалтгүй дүнтэй гарсан
3. Тайлагнаж дүгнэдэггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 5. Засаг даргын мөрийн хөтөлбөрт төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн тодорхой заалт тусгагдсан байдаг уу?

1. Тийм, Засаг даргын мөрийн хөтөлбөрт төсвийн мэдээллийг ил тод байдлыг хангахад чиглэсэнтодорхой заалт орсон /Асуулт 6-г хариулна/
2. Үгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөрт энэ тухай заалт огт байхгүй /Асуулт 7-г хариулна/
3. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 6. Асуулт 5-д дурьдсан Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж дүгнэсэн үү?

1. Тийм, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаж дүгнэсэн ба хэрэгжилт сайн дүнтэй гарсан
2. Тийм, Засаг даргын шийдвэрийг тайлагнаж дүгнэдэг ч хэрэгжилт хангалтгүй дүнтэй гарсан
3. Тайлагнаж дүгнээгүй.
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 7. Орон нутгийн төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах тухай ямар нэг заалт Засаг даргын ИТХ-тай байгуулсан Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд байдаг уу?

1. Тийм, уг гэрээнд төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах тодорхой заалтууд орсон /Асуулт 8-г хариулна/
2. Үгүй, уг гэрээнд энэ тухай ямар нэгэн заалт ороогүй
3. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 8. Асуулт 7-д дурьдсан Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг ИТХ-аас дүгнэсэн үү?

1. Тийм, дээрх гэрээний төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах заалтуудын хэрэгжилтийг сайн гэж дүгнэсэн
2. Гэрээний хэрэгжилтийг нийтэд нь сайн буюу хангалттай гэж дүгнэсэн ч төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах заалтын хэрэгжилтийг тусгайлан үнэлээгүй буюу хангалтгүй гэж үнэлсэн
3. Үгүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй буюу дүгнэлт нь ил тод бус
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 9. Төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангахтай холбоотой тодорхой заалт Засаг даргын Тамгын газрын даргын байгуулсан үр дүнгийн гэрээнд байдаг уу? /Эхний хоёр хариултыг зэрэг эсвэл аль нэгийг нь 4-р хариулттай хамт сонгож болно/

1. Тийм, ийм тодорхой заалт ЗДТГ-ын даргын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд байдаг
2. Тийм, ийм тодорхой заалт Санхүүгийн хэлтсийн даргын ЗДТГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд байдаг
3. Үгүй, энэ талаар тодорхой заалт дээрх хоёр үр дүнгийн гэрээнд байхгүй
4. Үр дүнгийн гэрээ ил бус
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 10. Аймгийн (нийслэлийн) боловсрол, эрүүл мэндийн газрын дарга нарын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах тухай тодорхой заалтууд туссан уу? /Эхний хоёр хариултыг зэрэг эсвэл аль нэгийг нь 4-р хариулттай хамт сонгож болно/

1. Тийм, боловсролын газрын даргын Засаг даргатай байгуулсан гэрээнд тодорхой заалт бий
2. Тийм, эрүүл мэндийн газрын даргын Засаг даргатай байгуулсан гэрээнд тодорхой заалт бий
6. Үгүй, энэ талаар тодорхой заалт дээрх хоёр үр дүнгийн гэрээнд байхгүй
3. Үр дүнгийн гэрээ ил бус учраас тогтоох боломжгүй.
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 11. Орон нутгийн төсвийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд өгч байх тухай тогтсон албан ёсны шийдвэр, журам байдаг уу?

1. Тийм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд өгч байх тухай Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, журам байдаг
2. Тийм, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд өгч байх тухай Засаг даргын шийдвэр, журам байдаг
3. Үгүй, ийм шийдвэр, журам байхгүй боловч сэтгүүлчид төсвийн мэдээллийг чөлөөтэй авч болдог
4. Үгүй, ийм шийдвэр, журам зохицуулалт байхгүй бөгөөд сэтгүүлчид төсвийн мэдээллийг чөлөөтэй авч чаддаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

## Хоёрдугаар хэсэг. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### ТӨСВИЙН САНАЛ:

Асуулт 12. Орон нутгийн төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг Сангийн яаманд илгээхээс өмнө олон нийтэд танилцуулдаг уу?

1. Тийм, төсвийн хүрээний мэдэгдлийг Сангийн яаманд илгээхээс өмнө олон нийтэд танилцуулдаг
2. Тийм, гэхдээ зөвхөн хүсэлт гаргасан иргэдэд төсвийн хүрээний мэдэгдлийг танилцуулдаг
3. Үгүй, төсвийн хүрээний мэдэгдлийг олон нийтэд ил танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 13. Орон нутгийн төсвийн саналыг Сангийн яаманд илгээхээс өмнө олон нийтэд танилцуулдаг уу?

1. Тийм, төсвийн саналыг Сангийн яаманд илгээхээс өмнө олон нийтэд ил танилцуулдаг
2. Тийм, гэхдээ зөвхөн хүсэлт гаргасан иргэдэд төсвийн саналыг танилцуулдаг
3. Үгүй, төсвийн саналыг олон нийтэд ил танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

## **ТӨСВИЙН ТӨСӨЛ:**

Асуулт 14. Орон нутгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-аас орон нутгийн төсвийн төслийг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээс өмнө олон нийтэд танилцуулдаг уу?

1. Тийм, Засаг дарга, ЗДТГ-аас төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлэхээс хоёр долоо хоногийн өмнө олон нийтэд нээлттэй танилцуулдаг
2. Тийм, Засаг дарга, ЗДТГ-аас төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлэхээс өмнө, гэхдээ хоёр долоо хоног хүрэхгүй хугацаанд олон нийтэд нээлттэй танилцуулдаг
3. Тийм, гэхдээ зөвхөн хүсэлт гаргасан иргэдэд төсвийн төслийг танилцуулдаг
4. Үгүй, төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлэхээс өмнө олон нийтэд танилцуулдаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 15. Орон нутгийн Засаг дарга төсвийн төслийг орон нутгийн хуралд албан ёсоор хэзээ ирүүлдэг вэ?

1. 12 дугаар сарын 1-нээс өмнө ирүүлдэг
2. 12 дугаар сарын 1-нээс хойш, гэхдээ 12 сарын 15-наас өмнө ирүүлдэг
3. 12 дугаар сарын 15-наас хойш, гэхдээ ИТХ-аар төслийг хэлэлцэхээс долоо хоногийн өмнө ирүүлдэг
4. ИТХ-аар төслийг хэлэлцэхийн өмнөх долоо хоногт ирүүлдэг
5. ИТХ-аар төсвийг хэлэлцэх хуралдаанд шууд танилцуулдаг
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 16. Төсвийн төсөлд төсвийн зарлагыг ямар ангиллаар танилцуулдаг вэ?

1. Эдийн засгийн, байгууллагын болон хөтөлбөр, үйл ажиллагааны ангиллаар бүгдээр
2. Зөвхөн эдийн засгийн ба байгууллагын ангиллаар
3. Зөвхөн эдийн засгийн эсвэл байгууллагын аль нэгээр
4. Нэгдсэн дүнгээр
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 17. Асуулт 16-д хариулсан ангиллын дагуу орон нутгийн төсвийн төсөлд зардлын зүйл заалтуудыг өмнөх хэдэн жилийн дүнтэй харьцуулж харуулдаг вэ?

1. Өмнөх 3 ба түүнээс дээш жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
2. Өмнөх 2 жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
3. Өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
4. Өмнөх жилүүдтэй харьцуулдаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....



Асуулт 18. Төсвийн төсөлд зарлагын гол зүйл ангиудын талаар хүүрнэсэн хэлбэрээр танилцуулсан нэмэлт тайлбар байдаг уу?

1. Тийм, төсвийн зарлагын гол зүйл ангиудын талаар дэлгэрэнгүй тайлбарыг хавсаргадаг
2. Төсвийн зарлагын гол зүйл ангиудын талаар товчхон тайлбарыг хавсаргадаг
3. Үгүй, нэмэлт тайлбар өгдөггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 19. Төсвийн төсөлд тухайн төсвийн жилээс цааш төсвийн зарлага хэрхэн өөрчлөгдөх тухай төсөөллийг оруулдаг уу?

1. Төсвийн жилээс цааш 2 жилийн төсөөллийг харьцуулан үзүүлдэг
2. Төсвийн жилээс цааш 1 жилийн төсөөллийг харьцуулан үзүүлдэг
3. Үгүй, ирээдүйн төсөөлөл харьцуулалтыг танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 20. Төсвийн төсөлд зарлагыг бодит, харьцуулж болох хэлбэрээр үзүүлсэн танилцуулга хийгддэг үү?

1. Төсвийн зарлагыг (аймгийн) ДНБ-д харьцуулсан байдлаар танилцуулдаг
2. Төсвийн зарлагыг инфляцийн түвшинтэй уялдуулж харьцуулсан байдлаар танилцуулдаг
3. Үгүй, бодит харьцуулалт хийсэн байдлаар зарлагыг танилцуулдаггүй
4. Бусад

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 21. Төсвийн төсөлд орлогын тухай иж бүрэн мэдээлэл ордог уу?

1. Төсвийн төсөлд орон нутгийн орлого, дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвийн санхүүжилтээр орон нутагт үзүүлэх үйлчилгээ зэрэг орлогын бүх эх үүсвэрийн мэдээллийг оруулдаг
2. Төсвийн төсөлд орон нутгийн орлого, дээд шатны төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг зэрэг орлогын зарим эх үүсвэрийн мэдээллийг оруулдаг
3. Төсвийн төсөлд орон нутгийн орлого, улсын төсвийн санхүүжилтээр орон нутагт үзүүлэх үйлчилгээ зэрэг орлогын зарим эх үүсвэрийн мэдээллийг оруулдаг
4. Төсвийн төсөлд зөвхөн орон нутгийн орлогын тухай мэдээллийг оруулдаг
5. Өөр бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 22. Төсвийн төсөлд орлогыг ямар ангиллаар танилцуулдаг вэ?

1. Орлогыг төвлөрүүлэгч байгууллага, орлого орж ирэх салбар, орлогын нэр төрлөөр танилцуулдаг
2. Төвлөрүүлэгч байгууллага, орлого орж ирэх салбар, орлогын нэр төрлийн хоёр үзүүлэлтээр нь танилцуулдаг
3. Төвлөрүүлэгч байгууллага, орлого орж ирэх салбар, орлогын нэр төрлийн аль нэг үзүүлэлтээр нь л танилцуулдаг
4. Төсвийн орлогыг ерөнхий дүнгээр нь л танилцуулдаг
5. Бусад

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 23. Төсвийн төсөлд орлогыг өмнөх жилийн орлоготой харьцуулсан байдлаар танилцуулдаг уу?

1. Өмнөх 3 ба түүнээс дээш жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
2. Өмнөх 2 жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
3. Өмнөх жилийн гүйцэтгэлтэй харьцуулдаг
4. Өмнөх жилүүдтэй харьцуулдаггүй
5. Бусад

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 24. Уул уурхай, хөдөө аж ахуй гэх мэт тухайн аймгийн эдийн засгийн үндсэн салбаруудаас орох орлогын талаар танилцуулсан тусгай хэсэг төсвийн төсөлд байдаг уу?

1. Тийм, эдийн засгийн бүх салбарын орлогыг нарийвчлан тайлбарласан тусгай хэсэг бий
2. Тийм, эдийн засгийн үндсэн салбарын зарим хэсгийн орлогыг тайлбарласан тусгай хэсэг бий
3. Үгүй, эдийн засгийн үндсэн салбаруудын орлогыг дэлгэрэнгүй тайлбарласан тусгай хэсэг байхгүй
4. Бусад

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 25. Төсвийн төсөлд орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн тухай мэдээлэл байдаг уу?

1. Тийм, төсвийн төсөлд орон нутгийн өмчийн бүх үйлдвэрийн газар, бизнесийн байгууллагуудын төсвийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл байдаг
2. Тийм, төсвийн төсөлд орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, бизнесийн байгууллагуудын төсвийн тухай мэдээлэл байдаг боловч мэдээлэл нь хангалттай дэлгэрэнгүй биш
3. Үгүй, төсвийн төсөлд орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар, бизнесийн байгууллагуудын төсвийн тухай мэдээлэл байдаггүй
4. Бусад

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 26. Төсвийн төсөлд орон нутгийн (аймгийн) хөгжлийн сангийн тухай мэдээллийг оруулдаг уу?

1. Тийм, төсвийн үйл явцын нэг хэсэг болгож аймагийн хөгжлийн сангийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгийн хуралд өгдөг (орлогын эх үүсвэр, зарлагын задаргааг бүрэн танилцуулдаг)
2. Тийм, төсвийн үйл явцын нэг хэсэг болгож аймагийн хөгжлийн сангийн тухай зарим мэдээллийг орон нутгийн хуралд өгдөг (нийт орлого зарлагын 50-70 хувьд тэнцэх хэсгийн орлогын эх үүсвэр, зарлагын задаргааг танилцуулдаг)
3. Тийм, төсвийн үйл явцын нэг хэсэг болгож аймагийн хөгжлийн сангийн тухай товч мэдээллийг орон нутгийн хуралд өгдөг (нийт орлого зарлагын 50 хувьд хүрэхгүй хэмжээтэй тэнцэх хэсгийн орлогын эх үүсвэр, зарлагын задаргааг танилцуулдаг)
4. Үгүй, аймаг /нийслэл/-ийн хөгжлийн сангийн тухай мэдээлэл төсөлд байдаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 27. Төсвийн төсөлд орлогын төлөвлөгөөнд учирч болох эрсдлүүдийн талаар (хүүрнэсэн хэлбэрээр) танилцуулдаг уу?

1. Тийм, орлого төвлөрүүлэхэд учирч болох эрсдлүүдийг дэлгэрэнгүй танилцуулдаг
2. Орлого төвлөрүүлэхэд учирч болох эрсдлүүдийн талаар товчхон танилцуулдаг
3. Үгүй, орлого төвлөрүүлэхэд учирч болох эрсдлүүдийн талаар танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 28. Төсвийн төсөлд орлого, зарлагын тухай мэдээллийг нийтэд ойлгомжтой график дүрслэлээр танилцуулдаг уу?

1. Төсвийн төсөлд график дүрслэлийг өргөнөөр ашигладаг
2. Төсвийн төсөлд цөөн тооны график дүрслэлийг ашигласан байдаг
3. Үгүй, төсвийн төсөлд график дүрслэл ашигладаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

**БАТЛАГДСАН ТӨСӨВ:**

Асуулт 29. Батлагдсан төсвийг олон нийтэд хэзээ ил тод болгодог вэ?

1. Төсөв батлагдсанаас хоёр долоо хоногийн дотор
2. Төсөв батлагдсанаас нэг сарын дотор
3. Төсөв батлагдсанаас гурван сарын дотор
4. Батлагдсан төсвийг албан ёсоор ил тод болгодоггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 30. Батлагдсан төсвийг олон нийтэд хэр дэлгэрэнгүй танилцуулдаг вэ?

1. Төсвийн орлого, зарлагыг байгууллага /төсвийн менежер/-аар, эдийн засгийн болон хөтөлбөр /үйл ажиллагааны/ дэлгэрэнгүй ангиллаар танилцуулдаг
2. Төсвийн орлого, зарлагыг байгууллага /төсвийн менежер/-аар болон эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллаар танилцуулдаг
3. Төсвийн орлого, зарлагыг байгууллага /төсвийн менежер/-аар танилцуулдаг
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 31. Батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулахдаа нэмэлт тайлбар мэдээллийг өгдөг үү?

1. Тийм, батлагдсан төсвийг хэрэгжүүлэх арга хэмжээ, нэмэлт дэлгэрэнгүй тайлбарын хамт танилцуулдаг
2. Батлагдсан төсвийг товч тайлбарын хамт танилцуулдаг
3. Батлагдсан төсвийг зөвхөн тоон хэлбэрээр нэмэлт тайлбаргүйгээр танилцуулдаг
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

**ТОДОТГОСОН ТӨСӨВ:**

Асуулт 32. Төсвийн тодотголын төслийг ИТХ-д танилцуулахаас өмнө Засаг дарга, Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-аас олон нийтэд танилцуулдаг уу?

1. Тийм, төсвийн тодотголын төслийг ИТХ-д танилцуулахаас өмнө олон нийтэд дэлгэрэнгүй танилцуулдаг
2. Тийм, төсвийн тодотголын төслийг ИТХ-д танилцуулахаас өмнө олон нийтэд хураангуй байдлаар танилцуулдаг
3. Үгүй, төсвийн тодотголын төслийг ИТХ-д шууд танилцуулдаг
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 33. Төсвийн тодотголын төслийг ИТХ-д хэзээ танилцуулдаг вэ?

1. Төсвийн тодотголыг хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдаанаас нэг сарын өмнө
2. ИТХ-ын хуралдаанаас хоёр долоо хоногийн өмнө
3. ИТХ-ын хуралдаанаас 3 хоногийн өмнө
4. ИТХ-ын хуралдааны өмнө ИТХ-д хүргүүлдэггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....



Асуулт 34. Төсвийн тодотголын төсөл хэр дэлгэрэнгүй байдаг вэ?

1. Үндсэн төсвийн төслийн нэгэн адил дэлгэрэнгүй
2. Зөвхөн тодотгол хийх зарлага, орлогын зүйл, заалтын тухай мэдээлэл, тайлбарын хамт
3. Зөвхөн тодотгол хийх зарлага, орлогын зүйл, заалтын тухай мэдээлэл
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 35. Батлагдсан тодотгосон төсвийг олон нийтэд ил тод болгодог уу?

1. Батлагдсанаас нь хойш хоёр долоо хоногийн дотор албан ёсоор олон нийтэд танилцуулдаг
2. Батлагдсанаас нь хойш нэг сарын дотор олон нийтэд танилцуулдаг
3. Батлагдсанаас нь хойш гурван сарын дотор олон нийтэд танилцуулдаг
4. Олон нийтэд танилцуулдаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 36. Батлагдсан тодотгосон төсвийг олон нийтэд хэр дэлгэрэнгүй танилцуулдаг вэ?

1. Тодотгосон төсвийг үндсэн төсвийн нэгэн адил дэлгэрэнгүй хэлбэрээр олон нийтэд танилцуулдаг
2. Тодотгосон төсвийг хураангуй хэлбэрээр буюу зөвхөн тодотгосон зүйл заалтыг олон нийтэд танилцуулдаг
3. Тодотгосон төсвийг олон нийтэд танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

#### **ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН:**

Асуулт 37. Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн явцын тайланг Иргэдийн төлөөлөгчдийн хуралд ямар хугацаанд ирүүлдэг вэ?

1. Сар тутам
2. Улирал тутам
3. Хагас жил тутам
4. Жил бүр
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 38. Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс төсвийн гүйцэтгэлийн явцын тайланг олон нийтэд ямар хугацаанд танилцуулдаг вэ?

1. Сар тутам
2. Улирал тутам
3. Хагас жил тутам
4. Жил бүр
5. Танилцуулдаггүй
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 39. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланг ИТХ-аар хэзээ хэлэлцэн баталдаг вэ?

1. Тухайн төсвийн жил дууссанаас 5 сарын дотор
2. 7 сарын дотор
3. 10 сарын дотор
4. Нэг жилийн дотор
5. Нэг жил, түүнээс дээш хугацааны дараа
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 40. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайлан хэр дэлгэрэнгүй байдаг вэ?

1. Санхүүгийн үзүүлэлтүүд эдийн засгийн болон байгууллагын ангиллаар, дэлгэрэнгүй тайлбарын хамт
2. Санхүүгийн үзүүлэлтүүд эдийн засгийн болон байгууллагын ангиллаар
3. Санхүүгийн үзүүлэлтүүд эдийн засгийн эсвэл байгууллагын аль нэг ангиллаар
4. Жилийн эцсийн төсвийн тайланг олон нийтэд ил мэдээлдэггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 41. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланд төсвийн гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулсан дэлгэрэнгүй тоон болон тайлбар /хүүрнэсэн/ мэдээлэл байдаг уу?

1. Төсвийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулдаг ба зөрүүг дэлгэрэнгүй тайлбарладаг
2. Төсвийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулдаг ч зөрүүг дэлгэрэнгүй тайлбарладаггүй
3. Төсвийн тайланд төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулсан мэдээллийг тайлагнадаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 42. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийг дэлгэрэнгүй танилцуулдаг уу?

1. Төсвийн тайланд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсөл бүрээр харьцуулдаг ба зөрүүг дэлгэрэнгүй танилцуулдаг
2. Төсвийн тайланд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг төсөл бүрээр харьцуулдаг ч зөрүүг дэлгэрэнгүй танилцуулдаггүй
3. Төсвийн тайланд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг цөөн хэдэн төслөөр харьцуулдаг ба зөрүүг дэлгэрэнгүй танилцуулдаг
4. Төсвийн тайланд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг цөөн хэдэн төслөөр харьцуулдаг ба зөрүүг дэлгэрэнгүй танилцуулдаггүй
5. Төсвийн тайланд хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулсан мэдээллийг танилцуулдаггүй
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

**АУДИТЫН ТАЙЛАН:**

Асуулт 43. Орон нутгийн аудитын газар аудитын тайлангаа олон нийтэд танилцуулдаг уу?

1. Тийм, аудитын газар иж бүрэн тайлангаа олон нийтэд танилцуулдаг
2. Тийм, гэхдээ зөвхөн тайлангийн хураангуй дүгнэлтийг олон нийтэд танилцуулдаг
3. Үгүй, аудитын газар тайлангаа олон нийтэд танилцуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 44. Орон нутгийн төр, захиргааны байгууллага аудитын дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээний талаар олон нийтэд тайлагнадаг уу?

1. Тийм, орон нутгийн төр, захиргааны байгууллага аудитын дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээнийхээ тайланг жил бүр олон нийтэд танилцуулдаг
2. Тийм, орон нутгийн төр, захиргааны байгууллага аудитын дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээнийхээ тайланг жил бүр аудитын газарт болон орон нутгийн хуралд тайлагнадаг
3. Орон нутгийн төр, захиргааны байгууллага аудитын дүгнэлтийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлдэг боловч тэр тухайгаа тайлагнадаггүй
4. Үгүй, орон нутгийн төр, захиргааны байгууллага аудитын тайлангийн мөрөөр ямар нэг арга хэмжээ авдаггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА (ТЕНДЕР):**

Асуулт 45. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, үйлчилгээний худалдан авалт (тендер)-ын журмуудаа нийтэд ил тод танилцуулдаг уу?

1. Тийм, тендер шалгаруулалт, худалдан авалтын журмуудаа нийтэд танилцуулдаг
2. Тийм, тендер шалгаруулалт, худалдан авалтын журмуудаа нийтэд танилцуулдаг, гэхдээ зөвхөн шаардсан тохиолдолд
3. Эдгээр журмуудын талаарх мэдээллийг зөвхөн тухайн тендерт оролцож байгаа хүмүүс авах боломжтой
4. Тендер шалгаруулалтын журмын тухай олон нийтэд мэдээлэл өгдөггүй буюу ийм журам гаргаагүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 46. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр зохион байгуулж буй худалдан авалт (тендер)-ын урилга, зарыг хэвлэл мэдээлэл, вэб хуудас, зарлалын самбар зэрэг хэрэгслээр хэзээ олон нийтэд хүргэдэг вэ?

1. Тендерийн материал хүлээж авахаас гурван сарын өмнө
2. Тендерийн материал хүлээж авахаас сарын өмнө
3. Тендерийн материал хүлээж авахаас хоёр долоо хоногийн өмнө
4. Тендерийн материал хүлээж авахаас хоёр долоо хоногийн дотор
5. Тендерийн урилга, зарыг олон нийтэд өгдөггүй
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 47. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгддэг худалдан авалт (тендерийн)-ын үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нийтэд ил болгодог уу?

1. Тийм, худалдан авалт (тендер)-ыг шалгаруулахаас өмнө үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нийтэд ил болгодог
2. Тийм, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг танилцуулдаг, гэхдээ шалгаруулалт дууссаны дараа эсвэл шаардсан тохиолдолд өгдөг
3. Үгүй, үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нийтэд ил болгодоггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 48. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгддэг худалдан авалт (тендер)-ын шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор тендерт оролцсон болон шалгарсан компаниудын тухай мэдээллийг ил тод болгодог уу?

1. Тийм, тендер шалгаруулалт, тэдгээрт оролцсон болон шалгарсан компаниудын тухай дэлгэрэнгүй мэдээллийг ил тод болгодог
2. Тендер шалгаруулалтын тухай зарим мэдээллийг өгдөг боловч зөвхөн шалгарсан компаниудын тухай мэдээллийг ил тод болгодог
3. Тендер шалгаруулалтын тухай зарим мэдээллийг өгдөг боловч тендерт оролцсон болон шалгарсан компаниудын тухай мэдээллийг ил тод болгодоггүй
4. Үгүй, тендер шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод болгодоггүй
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....



## Гуравдугаар хэсэг. ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Асуулт 49. Орон нутгийн Засаг дарга төсвийн төслөө Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихаас өмнө олон нийтээр уулзалт, ярилцлага зэрэг хэлбэрээр хэлэлцүүлдэг үү?

1. Тийм, Засаг дарга төсвийн төслөө орон нутгийн хуралд өргөн барихын өмнө сонирхсон иргэдийг оролцуулан хэлэлцүүлдэг
2. Үгүй, ийм арга хэмжээ зохион байгуулдаггүй
3. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 50. Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Засаг даргын өргөн барьсан төсвийн төслийн талаар олон нийтэд зориулсан хэлэлцүүлэг/сонгол хийдэг үү?

1. Тийм, ИТХ-аас Засаг даргын өргөн барьсан төсвийг хэлэлцэж батлахын өмнө олон нийтийн хэлэлцүүлэг/сонгол хийдэг
2. Үгүй, тийм хэлэлцүүлэг/сонгол хийдэггүй
3. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 51. Иргэдийн төлөөлөгчдийн хурал орон нутгийн төсөв хэлэлцэх хуралдааныг нээлттэй явуулдаг уу?

1. Тийм, ИТХ-ын хуралдааныг орон нутгийн радио телевизээр бүрэн эхээр нь шууд дамжуулдаг
2. Тийм, ИТХ-ын хуралдаанд иргэд оролцох нээлттэй
3. Тийм, ИТХ-ын хуралдаанд зөвшөөрөл авсан иргэд оролцох нээлттэй
4. Тийм, ИТХ-ын хуралдаанд иргэд оролцох нээлттэй ч бодит бэрхшээлээс болж иргэд оролцох боломж хязгаарлагддаг
5. Үгүй, хуралдаанд иргэд орох боломжгүй
6. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 52. Орон нутгийн төр, захиргааны байгууллагууд төсвийн төслийг хэлэлцэж батлахын (батлуулахын) өмнө олон нийтээс уг төсөлтэй холбоотой санал шүүмжлэл бичгээр авдаг уу? /Эхний хоёр асуултыг давхар сонгож болно/

1. Тийм, Засаг дарга, ЗДТГ төсвийн төслийн талаар олон нийтээс бичгээр санал авдаг
2. Тийм, орон нутгийн ИТХ төсвийн төслийн талаар олон нийтээс бичгээр санал авдаг
3. Үгүй, орон нутгийн удирдлага олон нийтээс бичгээр санал авдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 53. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ИТХ-аар орон нутгийн төсвийг хэлэлцэж байгаа талаар мэдээлдэг үү?

1. Тийм, төсвийн хэлэлцүүлгийн талаар орон нутгийн сонин, телевиз, радиогоор дэлгэрэнгүй мэдээлдэг
2. Төсвийн хэлэлцүүлгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд товчхон мэдээлэл өгдөг
3. Үгүй, төсвийн хэлэлцүүлгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлдэггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

---

Асуулт 54. Орон нутгийн удирдлагууд батлагдсан төсвийн талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулдаг уу? /Эхний хоёр асуултын хувьд давхар сонгож болно/

1. Тийм, төсөв батлагдмагц ИТХ хэвлэлийн бага хурал хийдэг
2. Тийм, төсөв батлагдмагц Засаг дарга хэвлэлийн бага хурал хийдэг
3. Үгүй, орон нутгийн төсөв батлагдсантай холбогдуулж хэвлэлийн бага хурал хийдэггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар:.....

Асуулт 55. Аймгийн төвд орон нутгийн төсвийн талаар шинэлэг мэдээлэл агуулсан олон нийтэд зориулсан мэдээллийн самбар бий юу?

1. Тийм, мэдээллийн самбартаа төсвийн тухай цэгцтэй, олон нийтэд ойлгогдохуйц мэдээллүүд тавьж иргэд үзэж болохоор газар байрлуулдаг
2. Тийм, олон нийтийн мэдээллийн самбарт төсвийн тухай мэдээлэл бий, гэхдээ олон нийт үзэх боломж багатай газар байрладаг буюу ойлгогдох хэлбэрээр мэдээллийг байршуулдаггүй
3. Үгүй, олон нийтийн мэдээллийн самбарт төсвийн тухай мэдээлэл байдаггүй, эсвэл тийм самбар байхгүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 56. Төсвийн хамгийн сүүлийн үеийн баримт бичгүүдийг орон нутгийн номын санд тавьдаг уу?

1. Номын санд төсвийн мэдээллийг тавьдаг ба хамгийн сүүлчийн үеийн мэдээллийг номын сангаас авч болно.
2. Номын санд төсвийн мэдээллийг тавьдаг хэдий ч хамгийн сүүлчийн үеийн мэдээлэл байдаггүй
3. Номын санд төсвийн мэдээллийг тавьдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 57. Орон нутгийн төсөв болон төсвийн байгууллагуудын төсвийн тухай мэдээллийг иргэдэд танилцуулах “нээлттэй өдөр”, уулзалт, ярилцлага зэрэг арга хэмжээ зохион байгуулдаг уу?

1. Тийм, төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор ийм арга хэмжээ зохион байгуулдаг
2. Тийм, ийм арга хэмжээ зохион байгуулж, орон нутгийн захиргааны үйл ажиллагаатай холбоотой өргөн хүрээтэй асуудлууд, түүний дотор төсөвтэй холбоотой асуудлыг танилцуулдаг
3. Үгүй, ийм арга хэмжээ зохион байгуулдаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 58. Орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд тойрогтоо зарцуулах хөрөнгө оруулалтын 500 сая, эсвэл 1 тэрбум төгрөгийг хэрхэн ашиглах талаар нутгийн иргэдтэй зөвлөлдөж, зарцуулалтаа тайлагнасан уу?

1. Тийм, сонгогдсон УИХ-ын гишүүд бүгд тойрогтоо зарцуулах хөрөнгийн ашиглалтын талаар иргэд олон нийттэй зөвлөлдөж тэдэнд тайлагнадаг
2. Тийм, гэхдээ зарим гишүүд л тойрогт зарцуулах хөрөнгөө хэрхэн ашиглах буюу ашигласан талаар олон нийттэй зөвлөлддөг
3. Үгүй, ингэж зөвлөлдөж тайлагнадаггүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

Асуулт 59. Орон нутгаас сонгогдсон УИХ-ын гишүүд тойрогтоо зарцуулах хөрөнгө оруулалтын 500 сая, эсвэл 1 тэрбум төгрөгийг хэрхэн ашиглах талаар орон нутгийн ИТХ, Засаг даргын тамгын газартай зөвлөлдөж, зохицуулалт хийсэн үү?

1. Тийм, сонгогдсон УИХ-ын гишүүд бүгдээрээ тойрогтоо зарцуулах хөрөнгийн ашиглалтын талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагатай зөвлөлдөж ажлаа уялдуулдаг
2. Зарим гишүүд л тойрогтоо зарцуулах хөрөнгийн ашиглалтын талаар орон нутгийн төр, захиргааны байгууллагатай зөвлөлдөж ажлаа уялдуулдаг
3. Үгүй, ингэж зөвлөлдөж, уялдуулдаг тохиолдол байхгүй
4. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

---

Асуулт 60. Орон нутгийн төсвийн тухай мэдээллийг орон нутгийн төр захиргааны байгууллагын албан ёсны вэбсайт дээр байрлуулдаг уу?

1. Тийм, төсвийн тухай иж бүрэн мэдээллийг байрлуулж тогтмол шинэчилдэг
2. Тийм, төсвийн тухай хуучирсан эсвэл цөөн тооны мэдээлэл л байдаг
3. Вэбсайт бий, гэхдээ төсвийн тухай мэдээлэл байхгүй буюу бараг байхгүй
4. Орон нутгийн захиргааны вэбсайт байхгүй буюу ажиллахгүй байгаа
5. Бусад хариулт

Эх сурвалж: .....

Тайлбар: .....

*Асуулга төгсөв.*

### 6.3. Асуулгыг бөглөх заавар

#### СУДАЛГААНЫ АСУУЛГА БӨГЛӨХ ЗААВАР

##### *- Орон нутаг дахь судлаачдад зориулсан аргачлал -*

Энэхүү заавар нь Монгол Улсын Орон нутгийн төсвийн ил тод байдлын 2011 оны индексийг тооцоход шаардлагатай судалгааны мэдээллийг орон нутгаас цуглуулах ажлын удирдамж болох юм.

##### ***Судлаачдад тавигдах шаардлага:***

Орон нутгаас судалгааны мэдээлэл цуглуулж асуулга бөглөх судлаач нь:

- Тухайн орон нутгийн байнгын оршин суугч байх
- Иргэний нийгмийн төлөөлөл эсвэл иргэний нийгмийн үзэл санааг идэвхтэй дэмждэг, ашиг сонирхлын зөрчилгүй байх
- Судалгааны асуулгыг ямар нэгэн нам, улс төр, бизнесийн ашиг сонирхлоос ангид байж, зааврын дагуу үнэн зөв, тодорхой, нягт нямбай бөглөх үүрэгтэй.

##### ***Судалгааны асуулгын тухай:***

Судалгааны асуулга нь орон нутгийн төсвийн баримт бичгийн ил тод байдлыг харуулсан хоёр хүснэгт, төсөв болон төсвийн үйл явцын ил тод, нээлттэй байдлыг үнэлсэн 3 хэсэг бүхий 60 асуулгаас бүрдэнэ.

##### ***Судалгааны асуулга бөглөх ерөнхий аргачлал:***

##### **Нэг. Төлөвлөх**

1. Асуулгыг хэвлэж аваад анхааралтай уншиж асуулт тус бүрээр ямар албан тушаалтан, байгууллагад хандаж хариулт авахаа тэмдэглэнэ.
2. Ихэнх тохиолдолд нэг албан тушаалтан, байгууллагаас нэлээд хэдэн асуултын хариултыг авах шаардлагатай тул тэдгээр асуултыг бүгдийг тэмдэглэж нэгтгээд нэг уулзалтаар үлдээлгүй асууж ярилцах, холбогдох төсвийн бичиг баримтыг гаргуулахаар төлөвлөх нь зүйтэй.
3. 2010 оны 12-р сарын сүүлчээр төсөв хэлэлцсэн орон нутгийн ИТХ-ын хуралдааны өмнө, хуралдааны үеэр болон дараа цуглуулсан мэдээлэл, албан тушаалтнуудтай уулзаж ярилцсан тэмдэглэл, тэднээс гаргуулж авсан баримт бичгүүдээ дахин үзэж ашиглаарай. Нэлээд асуултын хариулт ба эх сурвалжууд бэлэн байх боломжтой.

### **Хоёр. Уулзалт, ярилцлага хийх, очиж танилцах**

1. Ихэнх асуултын дагуу аймгийн (нийслэлийн) Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга, ЗДТГ-ын дарга, санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, хариуцлагатай ажилтан гэх мэт албан тушаалтнуудтай уулзаж тэдэнд хамаарах асуултуудыг тавьж хариулт авч нэгбүрчлэн тэмдэглэх ба тэдний ярьсныг нотлох баримт бичгүүдийг гаргуулж авна.
2. Зарим асуултын дагуу бусад оролцогч талууд болох сэтгүүлчид, иргэний нийгмийн төлөөлөл болон иргэдтэй уулзаж ярилцан олж авсан мэдээллээ тэмдэглэж баталгаажуулна.
3. Зарим асуултын дагуу аймгийн (нийслэлийн) Засаг даргын тамгын газрын байр, номын сан, Интернет мэдээллийн төв зэрэг газруудаар өөрийн биеэр очиж төсвийн холбогдолтой ямар мэдээлэл байгаа, хэр нээлттэй байгааг үзэж тэмдэглэх, боломжтой бол гэрэл зураг авах зэргээр баталгаажуулна.
4. Зарим асуултын дагуу сонин хэвлэлийн дугаар, телевизийн нэвтрүүлгээр болон вэб сайтад гарсан төсвийн холбогдолтой нийтлэл, нэвтрүүлэгтэй танилцаж эх сурвалжийг тэмдэглэн баталгаажуулахын зэрэгцээ боломжтой бол нэг хувийг олж авна.
5. Зарим асуултын дагуу шаардлагатай гэж үзсэн бусад эх сурвалжаас мэдээлэл цуглуулж болно.

**Гурав. Шаардлагатай бүх мэдээллийг цуглуулж баталгаажуулсны дараа асуулгыг эцэслэн бөглөнө. Асуулт болгоны төгсгөлд эх сурвалжийг заах ба тайлбар хийнэ.**

### ***Төсвийн баримт бичгийн хүснэгтийг бөглөх тухай:***

#### ***Хүснэгт 1.***

Энэ хүснэгт нь тухайн судалгааны асуултуудыг бөглөхөд ашигласан баримт бичгүүдийн тухай мэдээллийг агуулна. “Хамарвал зохих жил” баганад төсвийн аль жилийг хамарсан баримт бичиг байвал зохистойг заасан болно. “Судалгаанд хамарсан төсвийн жил” баганад бодитойгоор ашигласан баримт бичгийн хамарсан төсвийн жилийг тавина.

Судалгааг хийж байх үед нийтэд ил болсон хамгийн сүүлийн үеийн төсвийн баримт бичигт үндэслэн асуулгыг бөглөхийг зорих ёстой. Үүнээс хамаарч 2, 3-р баганы мэдээлэл ижил байх, эсвэл 3-р багана нь 2-р баганад тэмдэглэсний



дараачийн төсвийн он байх учиртай. Тухайлбал, төсвийн төслийн хувьд 2010 оны сүүлээр хэлэлцэн баталсан 2011 оны төсвийн төслийг ашиглах боломжтой. Харин аудитын тайлангийн хувьд 2010 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан хараахан гараагүй тул 2009 оныхыг ашиглана гэсэн үг. Хүснэгтийн 4 дэх баганад тухайн төсвийн баримт бичгийн албан ёсны нэр, олон нийтэд, эсвэл судлаачид тухайн баримт бичгийг ил болгосон буюу өгсөн огноо, хэрэв тухайн баримт бичиг интернэт дээр байгаа бол вэб холбоосыг нь бүтнээр (зөвхөн вэб хаягийг бичих нь хангалтгүй) бичнэ.

#### *Хүснэгт 2.*

Энэ хүснэгт нь орон нутгийн төсвийн үйл явцад ашигладаг үндсэн 10 баримт бичгийн ил тод, нээлттэй байдал, ил тод болгож байгаа хэлбэрт үнэлгээ өгөх зорилготой юм. Хүснэгт нь 2 хэсэг бөгөөд эхний хэсэгт зөвхөн “Тийм” гэж хариулахаар бол бичнэ. Харин хоёрдахь хэсэгт төсвийн мэдээллийг ил болгож байгаа хэлбэртэй холбоотой асуултууд орсон ба үүнд “Тийм”, “Үгүй” гэсэн хоёр асуултаас сонгоно.

#### ***1-60-р асуултанд хариулт авч буюу судлаж бөглөх заавар:***

Ихэнх асуултанд нэг хариулт сонгох бөгөөд тодорхой заасан цөөн хэдэн асуултанд хоёр хариултыг сонгож болно. Асуулт бүрт “Бусад хариулт” гэсэн сонголт бий. Мөн асуулт болгоны төгсгөлд “Эх сурвалж”, “Тайлбар” гэсэн судлаач бөглөх боломжтой хоосон зай байгаа. “Бусад хариулт”-ыг сонгосон тохиолдолд “Тайлбар” хэсгийг заавал бөглөнө. “Эх сурвалж” хэсэгт тухайн хариултыг сонгохдоо ямар баримтыг үндэслэсэн, тухайлбал төсвийн ямар баримтын хэддүгээр хуудас, ямар албан тушаалтантай хийсэн ярилцлага зэргийг тодорхой бичнэ.

## **Нэгдүгээр хэсэг. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН БАРИМТ БИЧГҮҮДИЙГ ИЛ ТОД БОЛГОХ ЭРХ ЗҮЙН ШААРДЛАГУУД**

*(Энэ хэсэг нь төсвийн баримт бичгүүдийг ил болгох хууль, эрх зүйн механизм тухайн орон нутагт бүрэлдсэн эсэх, бодит байдал дээр хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх зорилготой. Энэ хэсгийг бөглөхдөө судлаачид орон нутгийн албан тушаалтнуудтай ярилцлага хийхийн зэрэгцээ тухайн тогтоол, шийдвэр зэрэг баримт бичгийн эх сурвалжийг заана. Ингэхдээ тухайн баримт бичгийн хувийг авч хадгалах ёстой).*

### *Асуулт 1.*

Төр захиргааны байгууллагууд мэдээллийг олон нийтэд танилцуулах дотоод журамтай байх нь элбэг. Энэ асуулт нь орон нутгийн ИТХ-ын түвшинд ийм журмууд байгаа эсэхийг тогтоох зорилготой. Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, ИТХ-ын дарга, гишүүдээс уг мэдээллийг олж авах боломжтой. Түүнчлэн аймгийн санхүүгийн хэлтсийн ажилтнуудаас мэдээллийг лавлан нягтлах боломжтой. Хууль журам, тогтоол зэргийн хуулбар, дугаарыг авч, “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэж, шаардлагатай бол нэмэлт тайлбар хийнэ. “Тийм” хариулт нь ИТХ-ын тогтоол, бусад гэсэн хоёр сонголттой ба “Бусад” гэсэн хариултыг сонгох бол яг ямар баримт бичиг болох нэрийг бичиж, “Эх сурвалж”, “Тайлбар” хэсгийг мөн бөглөнө.

### *Асуулт 2.*

1-р асуулттай холбоотой энэ асуулт нь тухайн шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх зорилготой. Хэрэгжилтийг үнэлэх тайлан байдаг эсэхийг ИТХ-аас лавлаж, уг асуултад хариулна. Холбогдох тайлангийн аль хэсгийг үндэслэж хариултыг сонгож байгаагаа “Эх сурвалж” хэсэгт бичих ба тайланг хавсаргана.

### *Асуулт 3.*

Энэ асуулт нь 1-р асуулттай төстэй бөгөөд Засаг даргын түвшинд ийм журмууд байгаа эсэхийг тогтоох зорилготой. Засаг даргын тамгын газар, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнуудаас мэдээллийг лавлан нягтлах боломжтой. Журам, тогтоол зэргийн хуулбар, дугаарыг авч, “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэж, шаардлагатай бол нэмэлт тайлбар хийнэ. “Тийм” хариулт нь “ЗД-ын захирамж”, “Бусад” гэсэн хоёр сонголттой ба “Бусад” гэсэн хариултыг сонгох бол яг ямар баримт бичиг болох нэрийг бичиж, “Эх сурвалж”, “Тайлбар” хэсгийг мөн бөглөнө.

#### *Асуулт 4.*

3-р асуулттай холбоотой энэ асуулт нь тухайн шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх зорилготой. Хэрэгжилтийг үнэлэх тайлан байдаг эсэхийг ЗДТГ, Санхүүгийн хэлтсээс лавлаж, уг асуултад хариулна. Холбогдох тайлангийн аль хэсгийг үндэслэж хариултыг сонгож байгаагаа “Эх сурвалж” хэсэгт бичих ба тайланг хавсаргана.

#### *Асуулт 5.*

Засаг даргын мөрийн буюу үйл ажиллагааны хөтөлбөр бол орон нутгийн засаг захиргааны дөрвөн жилийн томилгооны хугацаанд Засаг даргын зүгээс хийх ажлын үндэс суурь бөгөөд бодлогын үндсэн баримт бичгүүдийн нэг байдаг. Судлаач мөрийн хөтөлбөртэй танилцаж, ишлэж, хуулбарыг судалгааны материалд хавсаргана.

#### *Асуулт 6.*

Өмнөх асуулттай холбоотой энэ асуулт нь мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээнд үндэслэх ба төсвийн ил тод байдлын тухай тусгайлсан үнэлгээ хийгдээгүй бол энэ тухай тайлбар хэсэгт бичнэ. Судлаач мөрийн хөтөлбөртэй танилцаж, ишлэж, хуулбарыг судалгааны материалд хавсаргана.

#### *Асуулт 7.*

ЗД-ын ИТХ-тай байгуулах Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ гэрээ нь тухайн орон нутагт төсвийг захиран зарцуулах, хариуцлага хүлээх үндсэн механизмуудын нэг болдог ч ил тод байдлын талаар тодорхой шаардлагууд ордог эсэх нь тодорхой биш юм. Тиймээс судлаач Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг ил байгаа эсэхийг нягталж, тухайн гэрээнд төсвийн ил тод, нээлттэй байдлын талаар ямар нэгэн заалт орсон эсэхийг үнэлнэ. Холбогдох эх сурвалж, тайлбарыг хариултын нэмэлт хэсэгт хийнэ.

#### *Асуулт 8.*

Өмнөх асуулттай холбоотой энэ асуулт нь Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний хэрэгжилтийг хэрхэн үнэлдэг талаар тодруулж байгаа. Гэрээний хэрэгжилтийг үнэлсэн баримт бичгийг ИТХ, ЗДТГ-аас аль алианаас нь авч танилцах боломжтой.

*Асуулт 9.*

Төсвийн мэдээллийг ил болгоход онцгой үүрэгтэй албан тушаалтнууд нь Засаг дарга, ЗДТГ-ын дарга, Санхүүгийн асуудал харицсан хэлтсийн дарга нар юм. ЗД-ын ЗДТГ-ын даргатай байгуулсан, ЗДТГ-ын даргын Санхүүгийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд үндэслэн энэхүү асуултыг хариулна. Эхний хоёр хариултыг зэрэг сонгох боломжтойгоос гадна аль нэгийг нь 4-р хариулттай хамт сонгох боломжтойг анхаарна уу. Хэрэв 4-р хариултыг сонгосон бол шалтгаанаа “Тайлбар” хэсэгт тодруулна.

*Асуулт 10.*

Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг улсын төсвөөс шууд санхүүжүүлдэг ч орон нутгийн ЗД-тай үр дүнгийн гэрээ байгуулдаг билээ. Уг гэрээнд төсвийн ил тод байдлын талаар тодорхой заалт ордог эсэхийг энэ асуултаар үнэлэхийг зорино. ЗДТГ, Боловсролын болон эрүүл мэндийн газрын холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл авна. Эхний хоёр хариултыг зэрэг сонгох боломжтойгоос гадна аль нэгийг нь 4-р хариулттай хамт сонгох боломжтойг анхаарна уу. Хэрэв 4-р хариултыг сонгосон бол шалтгаанаа “Тайлбар” хэсэгт тодруулна.

*Асуулт 11.*

Энэ асуултыг хариулахад ЗДТГ, ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд, аймаг /нийслэл/-ийн хэвлэл мэдээллийн гол хэрэгслүүдийн удирдлагуудтай ярилцана. Холбогдох албан ёсны шийдвэрийг “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэж, нэмэлт тайлбар бичнэ.

## Хоёрдугаар хэсэг. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

### **ТӨСВИЙН САНАЛ:**

(12-13-р асуултаар төсвийн хүрээний мэдэгдэл ба төсвийн саналын ил тод байдлыг үнэлнэ)

#### *Асуулт 12.*

Засгийн газраас төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулж, УИХ-ын хаврын чуулганаар батлуулдаг ба уг мэдэгдлийг боловсруулах явцад орон нутгаас төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг авдаг билээ. ЗДТГ, санхүүгийн хэлтсээс уг саналыг боловсруулан явуулдаг ба энэ асуултад тус хүрээний мэдэгдлийн саналаа орон нутаг Сангийн яаманд илгээхдээ иргэддээ мөн нээлттэй дэлгэдэг эсэхийг үнэлэх юм. Санхүүгийн хэлтсээс төсвийн хүрээний саналын баримт бичгийг авах боломжтой

#### *Асуулт 13.*

Орон нутаг өөрийн ирэх жилийн төсвийн саналаа боловсруулан Сангийн яаманд 8-р сард явуулдаг билээ. Энэ асуултад тус саналаа орон нутаг Сангийн яаманд илгээхдээ иргэддээ мөн нээлттэй дэлгэдэг эсэхийг үнэлэх юм. Санхүүгийн хэлтсээс төсвийн хүрээний саналын баримт бичгийг авах боломжтой.

### **ТӨСВИЙН ТӨСӨЛ:**

*(14-28-р асуултауд орон нутгийн төсвийн төслийн баримт бичгийн тухай юм. Төсвийн төсөл нь төсвийн талаар хамгийн дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан, батлагдахаас нь өмнө ИТХ-аар хэлэлцдэг тул орон нутгийн хөгжилд хамгийн чухал үүрэгтэй төсвийн баримт бичиг юм. Тийм учраас төсвийн төсөл нь иргэдэд нээлттэй, иргэдэд болон ИТХ-ын төлөөлөгчдөд ойлгомжтой, иж бүрэн байх шаардлагатай юм. Хэрэв төсвийн төслийг олон нийтэд ил болгоогүй бол эдгээр асуултад бүгдэд нь хамгийн бага оноо бүхий хариу尔тыг сонгох шаардлагатай болно).*

*Асуулт 14.*

Төсвийн төслийг ЗД-ын зүгээс ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар 12-р сарын 1-ний дотор өргөн барих хуулийн заалттай билээ. Энэ асуултад ИТХ-д өргөн барихаас өмнө ЗД төсвийн төслийг боловсруулахдаа иргэдээс төсөвтэй холбоотой санал шүүмж авдаг эсэхийг үнэлэх юм. ЗДТГ, Санхүүгийн хэлтэс, ИТХ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцах, орон нутаг дахь иргэний нийгмийн байгууллагуудаас лавлах журмаар баримт бүрдүүлнэ. “Эх сурвалж” хэсэгт чухам ямар эх сурвалж дээр үндэслэн хариултыг сонгосон болохыг тодорхой тэмдэглэнэ.

*Асуулт 15.*

Төсвийн төслийг ЗД-ын зүгээс ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар 12-р сарын 1-ний дотор өргөн барих хуулийн заалттай билээ. Бодит амьдралд энэ шаардлага биелдэг эсэхийг уг асуулт үнэлэх зорилготой. Албан ёсны өргөн мэдүүлсэн захидал зэргийг эх сурвалж болгоно.

*Асуулт 16.*

Төсвийн зарлагыг үндсэн 3 ангиллаар танилцуулах боломжтой: 1/ эдийн засгийн, 2/ байгууллагын /эсвэл төсвийн захирагчийн/, 3/ хөтөлбөрийн /эсвэл үйлжиллагааны/. Жишээ нь зарлагыг цалинхөлс, захиргааны зардал, хөрөнгийн зардал зэргээр хуваах нь эдийн засгийн ангиллын дагуу харуулах, холбогдох төсвийн байгууллага буюу төсвийн захирагчаар, тухайлбал ЗДТГ, сумд, цагдаа, эмнэлэг г.м. хуваах нь байгууллагын буюу төсвийн захирагчийн ангиллын дагуу харуулах, харин боловсрол, эрүүл мэнд, хот байгуулалт, гамшигтай тэмцэх, мал аж ахуй гэх зэрэг нь үйл ажиллагааны буюу хөтөлбөрийн ангилалд тооцогдоно. Олон ангиллаар төсвийн зарлагыг үзүүлэх тусам иргэд ойлгоход дөхөм, мөн ИТХ бодитой мэдээлэлд үндэслэн шийдвэрээ гаргах боломжтой болно. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 17.*

Төсвийн зарлагыг өмнөх онуудын гүйцэтгэлтэй харьцуулах нь төсвийн ерөнхий чиг хандлагыг ойлгоход тустай. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 18.*

Төсвийн төсөлд орон нутгийн төсөвт зонхилох байр эзлэх зарлагуудын талаар нэмэлт тайлбар өгөх нь төсвийн мөн чанарыг ойлгоход дөхөм билээ. Тухайлбал, тухайн аймагт дэд бүтцийн хөрөнгө оруулалтанд тухайн төсвийн жилд ихээхэн хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн бол шалтгаан, тухайн хөрөнгө оруулалтын үр өгөөж, хэрэгжүүлэхэд учирч болох эрсдэл зэрэг асуудлыг бүрэн ойлгоход дөхөм мэдээллийг ИТХ болон иргэдэд өгөх нь чухал. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 19.*

Төсвийн зарлага ирэх жилүүдэд хэрхэн өөрчлөгдөхөөр төсөөлж байгаа, ЗД-ын мөрийн хөтөлбөр хэрэгжих бодит боломж байгаа эсэх зэрэг чухал төсөөлөл, дүгнэлт хийхэд төсвийг олон жилээр төлөвлөх практик онцгой ач холбогдолтой. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 20.*

Үнийн өсөлт, хүн амын өсөлт, эдийн засгийн өсөлт зэрэг олон шалтгаанаас хамааран хоёр жилийн төсвийн тоог шууд харьцуулах нь оновчгүй байдаг. Тухайлбал, инфляци буюу ерөнхий үнийн өсөлт өндөр үед төсвийн зарлага тухайн оны үнээр бага зэрэг нэмэгдсэн ч бодит утгаараа буурсан байх боломжтой. Мөн аймгийн хүн ам нэмэгдвэл тухайн зардал нэг хүнд ногдох утгаараа буурсан байх боломжтой. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 21.*

Орон нутаг дахь төрийн үйл ажиллагааг гурван эх үүсвэрээс санхүүжүүлдэг. Үүнд: орон нутгийн өөрийн орлого /тухайлбал орон нутгийн төсөвт төвлөрдөг татварын орлого/, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, улсын төсвөөс шууд санхүүжих үйл ажиллагаа зэрэг орно. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 22.*

Орлогыг байгууллага, салбар, нэр төрөл /эдийн засгийн/ зэрэг ангиллаар үзүүлэх нь төсвийн орлогыг бүрэн ойлгоход дөхөмтэй. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 23.*

Орлогыг өмнөх жилүүдтэй харьцуулах нь төсөв санхүүгийн байдлын чиг хандлагыг харах боломжийг олгоно. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 24.*

Төсвийн орлого хамаарах гол салбаруудын хувьд орлого төвлөрүүлэхэд учирч болзошгүй эрсдэл зэргийг ойлгоход орлогын төлөвлөгөөг тусгайлсан тайлбар хэсгээр баяжуулах нь шийдвэр гаргагчдад чухал ач холбогдолтой. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 25.*

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн орлого зарлага зах зээлээс хамааран хувьсан магадлал өндөр тул төсөвт эерэг болон сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл өндөр. Тиймээс эдгээр аж ахуйн нэгжүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг төсвийн төсөлд хамруулсан байх нь чухал. Зам засварын, дулаан хангамжийн, уул уурхайн (Таван толгой ХК) зэрэг төрөл бүрийн компаниуд орон нутгийн өмчийн хэлбэртэй байх боломжтой. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./



*Асуулт 26.*

Сүүлийн жилүүдэд уул уурхай зэрэг салбар эрчимтэй хөгжих болсонтой холбоотойгоор аймаг хөгжүүлэх сангийн хөрөнгө нэмэгдэх хандлагатай байгаа. Уг санг захиран зарцуулахад төсвийн бусад зарлагын нэгэн адил хэлэлцүүлэг, батламжлал, хяналт байх нь зохистой. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 27.*

Тухайн төсвийн жилийн явцад орлого төлөвлөсөн хэмжээнд бүрэлдэхгүй тохиолдолд төсвийг тодотгох, зарим үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй байх сөрөг үр дагавар үүсэх боломжтой тул орлого төвлөрүүлэхэд учирч болох эрсдлүүдийн талаар ИТХ болон иргэд бодит мэдээлэлтэй байх нь чухал. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

*Асуулт 28.*

Төсвийн төслийг тэр бүр санхүү төсвийн мэргэжлийн бус ИТХ, иргэдэд энгийн хялбар хэлбэрээр үзүүлж танилцуулахад график дүрслэл зэрэг чухал үүрэгтэй ба энэ асуултын хүрээнд ийм танилцуулга байгаа эсэхэд үнэлгээ өгөхийг зорьж байгаа. Уг асуултыг төсвийн төсөлтэй танилцах, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцах байдлаар баримтжуулж, эх сурвалжийг тодорхой бичнэ /жишээ нь төсвийн төслийн ... хуудас г.м./

**БАТЛАГДСАН ТӨСӨВ:**

*(29-31-р асуулт ИТХ-аас батлагдсан орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэх зорилготой. Засаг даргын өргөн мэдүүлсэн төсвийн төслийг ИТХ-аар төсвийн жил эхлэхээс өмнө хэлэлцэж батлах хуулийн заалттай)*

*Асуулт 29.*

Орон нутгийн төсөв ИТХ-аар батлагдмагц богино хугацаанд иргэд уг төсөвтэй танилцах боломжтой байх ёстой. Төсвийг олон нийтэд хүргэхэд цаг хугацаа алддаг эсэхийг энэ асуултын хүрээнд үнэлэх зорилготой. ИТХ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авах болон ажиглалтын үндсэн дээр энэ асуултыг хариулна.

*Асуулт 30.*

Төсвийн төслийн нэгэн адил дэлгэрэнгүй хэлбэрээр батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулах нь иргэд төсвийн талаар бодитой мэдээлэлтэй болох боломжийг нээх тул батлагдсан төсвийг ямар задаргаатай танилцуулдагийг энэ асуултаар үнэлэх юм. Судлаач батлагдсан төсөвтэй танилцах, ИТХ, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцсаны үндсэн дээр асуултад хариулт өгнө.

*Асуулт 31.*

Батлагдсан төсөв нь зөвхөн тоон хэлбэрээр бус нэмэлт бичгээр хүүрнэсэн тайлбарын хамт олон нийтэд танилцуулагдах нь төсвийг ойлгоход дөхөм болох тул эл асуултаар төсвийг нэмэлт тайлбарын хамт танилцуулдаг эсэхийг үнэлнэ. Судлаач батлагдсан төсөвтэй танилцах, ИТХ, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцсаны үндсэн дээр асуултад хариулт өгнө.

**ТОДОТГОСОН ТӨСӨВ:**

*(32-36-р асуултад төсвийн тодотголтой холбоотой асуултуудыг оруулав. Тухайн жилийн явцад төрөл бүрийн шалтгааны улмаас орлого төлөвлөсөн хэмжээнээс буурах буюу нэмэгдэх үед, мөн урьдчилан төлөвлөөгүй үйл явдлаас хамааран зарлага нэмж гаргах шаардлагатай бол орлого, зарлагын төлөвлөгөөг эргэн харж, тодотгох шаардлага үүсдэг. Орон нутгаас өөрөөс нь хамааралтай асуудлаас гадна улсын төсвийг тодотгосонтой холбоотойгоор орон нутгийн төсвийг тодотгох нь элбэг. Төсвийн тодотгол хийгдэх үед түүнийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх үйл явц төсвийг анх төлөвлөх, батлах, хэрэгжүүлэхийн нэгэн адил ил тод, нээлттэй явах нь чухал юм)*

*Асуулт 32.*

Асуултыг хариулахын тулд ЗДТГ, санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж, холбогдох нотолгоог судлаач авах шаардлагатай. Түүнчлэн төсвийн тодотголын төслийг зөвхөн тодотгол хийгдэх орлого зарлагын зүйлийн хувьд бэлтгэж, танилцуулдаг, эсвэл төсвийг бүхэлд нь орсон өөрчлөлтийн хамт танилцуулдаг эсэхийг энэ асуултаар тодруулах юм.

*Асуулт 33.*

Төсвийн тодотголын төсөлтэй ИТХ танилцах хангалттай хугацаа олгосноор тодотголын хэлэлцүүлэг чанартай болох тул төслийг хэзээ ИТХ-д танилцуулдагийг энэ асуултаар үнэлэх болно. ИТХ-ын болон ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авч, холбогдох баримт бичигтэй танилцаж, “Эх сурвалж” хэсгийг бөглөснөөр баталгаажуулна.

*Асуулт 34.*

Төсвийн тодотгол иж бүрэн байх нь өөрчлөлт нийт төсөвт хэрхэн нөлөөлөхийг харах боломжийг ИТХ, иргэдэд олгох болно. Төсвийн тодотголын баримт бичигтэй танилцуулж, төсвийн төслийн баримт бичигтэй харьцуулах замаар асуултад хариулна.

*Асуулт 35.*

Батлагдсан тодотгосон төсвийг олон нийтэд хугацаа алдалгүй мэдээлэх нь чухал ач холбогдолтой. Энэ асуултыг хариулахад ИТХ, ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авах ба “Тайлбар” хэсэгт чухам аль байгууллага /ИТХ эсвэл ЗДТГ/ уг мэдээллийг ил болгосныг тодорхой бичнэ.

*Асуулт 36.*

Батлагдсан тодотгол нь зөвхөн оруулсан өөрчлөлт, эсвэл өөрчлөгдсөн төсвийг бүхэлд нь танилцуулдаг эсэхийг уг асуултаар үнэлнэ. Энэ асуултыг хариулахад ИТХ, ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авах ба “Тайлбар” хэсэгт чухам аль байгууллага /ИТХ эсвэл ЗДТГ/ уг мэдээллийг ил болгосныг тодорхой бичнэ.

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН:**

*(37-42-р асуулт төсвийн гүйцэтгэлийн тайлангийн ил тод байдлыг харуулна. Төсвийн үйл явцад төсвийн гүйцэтгэлийг иргэд хянах боломжоор хангагдсан байх нь онцгой ач холбогдолтой).*

*Асуулт 37.*

Төсвийн тайланг сар тутам, улирал тутам, жил тутам гаргах боломжтой. Тухайн аймгийн вэб хуудаснаас мэдээллийг авахаас гадна ИТХ, ЗДТГ-ын холбогдох ажилтнаас мэдээлэл авч, тайланг ИТХ-д ирүүлсэн албан захидал зэргийг “Эх сурвалж” хэсэгт бичиж, баталгаажуулна.

*Асуулт 38.*

Төсвийн гүйцэтгэлийн тайланг ИТХ-д танилцуулахаас гадна олон нийтэд тогтмол танилцуулдаг байдлыг энэ асуултаар үнэлнэ. ЗДТГ, Санхүүгийн хэсгийн холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авч, вэб хуудсыг хянах зэргээр хариултыг баримтжуулна.

*Асуулт 39.*

Төсвийн жил дууссаны дараа богино хугацаанд төсвийн гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцэж, хяналт тавих боломжтой байгаа эсэхийг энэ асуултаар үнэлнэ. Төсвийн гүйцэтгэлийг аудитын дүгнэлтийн хамт ИТХ-д оруулдаг. ИТХ, ЗДТГ, Санхүүгийн хэсгийн холбогдох мэргэжилтнүүдээс лавлах замаар уг асуултад хариулна.

*Асуулт 40.*

Төсвийн тайлан ИТХ болон иргэдэд ойлгомжтой хэлбэрээр бичигдсэн байх ёстой ба чухам ямар ангиллаар тайланг бэлтгэдэг болохыг энэ асуултаар үнэлнэ. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланг үзэж байж судлаач энэ асуултад хариулна. Тайлангийн холбогдох хуудсыг “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэнэ.

*Асуулт 41.*

Тайлан дэлгэрэнгүй тоон болон текстэн мэдээлэл агуулах нь гүйцэтгэлийг хянахад чухал үүрэгтэй. Төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланг үзэж байж судлаач энэ асуултад хариулна. Тайлангийн холбогдох хуудсыг “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэнэ.

*Асуулт 42.*

Төсвийн зарлагын чухал хэсэг бол хөрөнгө оруулалтын төслүүдийн зардал билээ. Энэ асуултад хөрөнгө оруулалтын төслүүдийг биелэлтийг дэлгэрэнгүй тайлагнадаг эсэхэд үнэлгээ өгөх зорилготой. ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай ярилцаж мэдээлэл авч, төсвийн жилийн гүйцэтгэлийн тайланг үзэж байж судлаач энэ асуултад хариулна. Тайлангийн холбогдох хуудсыг “Эх сурвалж” хэсэгт тэмдэглэнэ.

### **АУДИТЫН ТАЙЛАН:**

*(43-44-р асуултууд төсвийн гүйцэтгэлд хийдэг аудитын тайлангийн ил тод байдлыг үнэлнэ).*

#### *Асуулт 43.*

Засаг дарга төсвийн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангаа аудитын байгууллагад илгээж, аудитын дүгнэлт гаргуулдаг билээ. Аудитын тайланг олон нийт олж мэдэх нь төсвийн гүйцэтгэлийн талаар хөндлөнгийн мэргэжлийн дүгнэлттэй танилцах боломжийг нээх тул уг тайлан ил байх нь онцгой ач холбогдолтой ба нээлттэй байдлыг энэ асуултаар үнэлнэ. Орон нутгийн болон аудитын байгууллагын вэб хуудас, аймаг нийслэлийн аудитын газрын холбогдох албан тушаалтнаас мэдээлэл авах замаар уг асуултад судлаач хариу өгнө.

#### *Асуулт 44.*

Аудитын дүгнэлтийн дагуу тодорхой арга хэмжээ авч, түүнийгээ олон нийтэд тайлагнадаг бол төсвийн гүйцэтгэлийн үр дүнг олон нийт эргэлзэхгүй байх, хариуцлага тооцох механизм ажиллаж байгаад итгэх болно. Энэ асуултаар тодорхой арга хэмжээ авдаг эсэх, түүнийгээ ИТХ-д тайлагнадаг эсэхийг тодруулах юм.

### **ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА (ТЕНДЕР):**

*(45-48-р асуултууд худалдан авах үйл ажиллагаа буюу тендерийн ил тод байдлыг үнэлнэ).*

#### *Асуулт 45*

Орон нутгийн түвшинд худалдан авах үйл ажиллагааг байнга зохион байгуулж байдаг ба үүнийг сайн зохион байгуулах нь төсвийн үр ашигтай зарцуулалтанд онцгой ач холбогдолтой. Худалдан авалт ямар дүрмээр явагдахыг олон нийт мэдэж байх нь чухал учир энэ асуултад уг журмыг ил болгодог эсэхэд үнэлгээ өгөх юм. ЗДТГ, Санхүүгийн хэлтэс, Аудитын газрын холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл авах, вэб хуудас болон бусад эх сурвалжуудтай танилцах замаар уг асуултад хариулна.

#### *Асуулт 46.*

Худалдан авалтын зар шалгаруулалтаас аль болох өмнө нь олон нийт, сонирхогч талуудад хүргэгдэх нь тендер өрсөлдөөнтэй явах нөхцлийг бүрдүүлэх тул энэ байдлыг уг асуултаар үнэлэх зорилготой. ЗДТГ, Санхүүгийн хэлтэс, Аудитын газрын холбогдох албан тушаалтнуудаас мэдээлэл авах, вэб хуудас болон бусад эх сурвалжуудтай танилцах замаар уг асуултад хариулна.

*Асуулт 47.*

Худалдан авалтын ажиллагаанд оролцогчдыг шалгаруулах үнэлгээний хороо ил байх нь олон нийт шударга шалгаруулалт явахад эргэлзэхгүй байх нэг хөшүүрэг тул энэ асуултад уг хорооны бүрэлдэхүүн ил байдаг эсэхэд үнэлгээ өгөхийг зорилоо. ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай уулзах, вэб хуудас болон бусад эх сурвалжаас мэдээлэл авч уг асуултад хариулна.

*Асуулт 48.*

Тендерт шалгарсан болон шалгараагүй компаниудын тухай мэдээлэл ил байх нь иргэд тэдний үйл ажиллагаа, гүйцэтгэлд үнэлгээ өгөх, улмаар төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг нээнэ. ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох албан тушаалтантай уулзах, вэб хуудас болон бусад эх сурвалжаас мэдээлэл авч уг асуултад хариулна.

## **Гуравдугаар хэсэг. ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ**

*Асуулт 49.*

Төсвийн төслийг боловсруулаад, 12 сарын 1-нээс өмнө ИТХ-д өргөн барихаас өмнө иргэдэд танилцуулдаг, тэдний саналыг авдаг байх нь иргэдийн оролцоог төсвийг боловсруулах үе шатанд хангахыг зорьж байгааг илэрхийлнэ. ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн холбогдох хүмүүс, уулзалт ярилцлагад оролцсон иргэний нийгмийн байгууллага, иргэдээс лавлаж байж асуултанд хариулна.

*Асуулт 50.*

ИТХ иргэдийн дунд хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулбал төсвийг батлах шийдвэрт иргэд шууд оролцох боломж бүрдэнэ. ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд, уулзалт ярилцлагад оролцсон иргэний нийгмийн байгууллага, иргэдээс лавлаж байж асуултанд хариулна.

*Асуулт 51.*

ИТХ-д иргэд оролцох боломжтой байх нь төсөв батлах үйл явц нээлттэй байх нэг үндэс. ИТХ-ын холбогдох албан тушаалтнууд, ИТХ-д оролцсон иргэд, өөрийн туршлагад үндэслэн асуултанд хариулна.

*Асуулт 52.*

ИТХ, ЗДТГ-аас төсвийн төслийн талаар бичгээр санал шүүмж авч, түүнийгээ төсвийн төсөлд тусгадаг байх нь нээлттэй төсвийн нэг хэлбэр. ЗДТГ, ИТХ-ын холбогдох албан тушаалтнуудаас лавлах, холбогдох баримт, саналтай танилцах замаар асуултад хариулна.

*Асуулт 53.*

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд төсвийн үйл явцын талаар иргэдэд шуурхай мэдээлэл хүргэх боломжоор хангагдсан байдлыг энэ асуултаар үнэлнэ. ИТХ, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй уулзаж лавлагаа авах замаар асуултыг баримтжуулж, хариулна.

*Асуулт 54.*

Батлагдсан төсөв нь тухайн орон нутгийн засаг захиргааны хувьд хамгийн чухал баримт бичиг тул хэвлэлийн бага хурал зарлаж, нийтэд мэдээлэл хүргэдэг байж болох юм. ИТХ, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй уулзаж лавлагаа авах замаар асуултыг баримтжуулж, хариулна.

*Асуулт 55.*

Аймгийн захиргаанд иргэдэд зориулсан мэдээллийн самбар байдаг ба энэ самбарт төсвийн мэдээлэл байдаг эсэхэд үнэлгээ өгнө. Мэдээллийн самбартай судлаач танилцах, ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн ажилтнуудтай ярилцах замаар асуултад хариулна.

*Асуулт 56.*

Төсвийн мэдээллийг аймгийн номын санд тавих нь иргэдэд хүргэх нэг суваг юм. Уг судалгаанд хамрах төсвийн жилийн мэдээллүүд номын санд байгаа эсэх, эсвэл төсвийн мэдээлэл байдаг ч цаг хугацааны хувьд нилээд хожуу номын санд тавигддаг эсэхийг уг асуудлаар үнэлэх юм. Хүснэгт 2-т төсвийн мэдээлэл номын санд байгаа эсэхийг тусгайлан асуусан ба тэр хэсгийг бөглөсөн байх шаардлагатай. Номын санч, ЗДТГ, ИТХ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, байгаа баримт бичигтэй судлаач өөрийн биеэр танилцах замаар асуултад хариулна.

*Асуулт 57.*

Нээлттэй өдөр, өдөрлөг, уулзалт ярилцлага зэргийг төр захиргааны байгууллагууд зохион байгуулж төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх боломжтой. ЗДТГ, Санхүүгийн хэлтсийн ажилтнуудтай ярилцах, ийм уулзалт өдөрлөгт оролцсон иргэдээс лавлагаа авах замаар асуултад хариулна.

*Асуулт 58.*

Орон нутгийн төсвөөс гадуур ч орон нутагт багагүй хөрөнгө оруулалтын ажлыг УИХ-ын гишүүдийн тойрогтоо зарцуулах хөрөнгөөр санхүүжүүлж ирсэн. УИХ-ын гишүүд иргэдийн хүсэл сонирхлыг зарцуулах шийдвэртээ тусгадаг эсэхийг уг асуудлаар лавлана. ЗДТГ, УИХ-ын гишүүний бие төлөөлөгч, тэдний гаргасан тайлан зэргийг үндэслэн уг асуултад хариулна.

*Асуулт 59.*

УИХ гишүүд тойрогтоо зарцуулах хөрөнгийг орон нутгийн удирдлагуудтай зөвшилцөн байж байршуулдаг эсэхийг уг асуултаар үнэлнэ. УИХ-ын гишүүд иргэдийн хүсэл сонирхлыг зарцуулах шийдвэртээ тусгадаг эсэхийг уг асуудлаар лавлана. ИТХ, ЗДТГ, УИХ-ын гишүүний бие төлөөлөгч, тэдний гаргасан тайлан зэргийг үндэслэн уг асуултад хариулна.

*Асуулт 60.*

Уг асуултаар орон нутаг вэб сайттай эсэх, түүнийгээ төсвийн мэдээллээр шинэчлэн баяжуулдаг эсэхэд үнэлгээ өгөх зорилготой. Вэб сайттай танилцах, ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнуудаас лавлагаа авах замаар уг асуултад хариулна.

Мэдээлэл цуглуулах ба асуулга бөглөх явцад тодруулах зүйл гарвал Улаанбаатар дахь судлаачдад и-мэйл болон утсаар чөлөөтэй хандаж зөвлөгөө авна уу.

*2011 оны 1-р сар.*



## 6.4. Асуулгын хариултууд

### Төсвийн баримт бичгийн ил тод байдалтай холбоотой асуултуудын хариулт

	Аудитын тайлан	Батлагдсан төсөв	Жилийн тайлан	Сар бүрийн тайлан	Төсвийн санал	Төсвийн тодотгол	Төсвийн төсөл	Төсвийн хүрээ	Улрал тутмын тайлан	Хураангуй төсөв
Архангай	4	3	4	2	2	3	3	2	3	4
Баян-Өлгий	2	3	3	2	3	3	3	2	2	3
Баянхонгор	4	4	4	1	3	3	3	3	1	3
Булган	4	4	4	3	3	3	4	3	1	1
Говь-Алтай	2	3	3	2	2	2	3	2	2	1
Говьсүмбэр	3	4	2	4	3	4	3	3	2	4
Дархан-Уул	2	4	4	2	2	2	3	2	2	1
Дорноговь	2	3	2	2	2	2	2	2	2	3
Дорнод	3	4	3	4	1	3	3	1	1	1
Дундговь	3	3	3	1	2	3	3	2	1	1
Завхан	3	3	3	2	3	3	3	3	2	3
Орхон	4	2	2	2	2	2	2	2	2	2
Өвөрхангай	4	4	4	1	3	3	3	3	1	3
Өмнөговь	2	4	3	2	1	3	3	2	2	1
Сүхбаатар	3	4	2	2	4	3	3	3	2	4
Сэлэнгэ	3	4	3	4	3	3	4	2	3	4
Төв	4	4	2	3	3	4	2	3	3	1
Увс	3	3	3	2	2	3	3	2	3	3
Улаанбаатар	4	4	4	4	4	2	4	2	4	4
Ховд	3	4	3	3	3	3	3	3	1	3
Хөвсгөл	3	3	3	3	2	3	3	2	3	4
Хэнтий	2	3	2	3	1	2	3	1	3	1

### Дээрх хүснэгтийн хариултыг тайлбарлах түлхүүр:

Хариулт	Түлхүүр
1	Огт боловсруулдаггүй
2	Зөвхөн албан хэрэгцээнд
3	Хүсэлт гарган авч болдог
4	Чөлөөтэй авч болдог

Үндсэн асуулгын хариултууд

Асуулт	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Улаанбаатар	Ховд	Хөвсгөл	Хэнтий
1	3	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	3	1	2	2	1	1	2
2	3	4	4	4	3	4	4	3	3	4	4	4	4	4	4	4	4	3	4	4	3	4
3	1	2	2	2	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	3	2	2	1	2	2	2
4	1	4	4	4	4	4	4	3	3	4	4	4	4	4	4	4	4	1	4	4	4	4
5	3	2	2	1	2	3	2	1	1	2	2	2	2	2	2	2	1	2	1	1	2	2
6	4	4	4	1	4	4	4	1	1	4	1	4	4	4	4	1	1	1	1	1	4	4
7	1	2	2	2	2	3	2	3	3	2	3	3	3	2	3	2	2	2	3	3	3	2
8	4	4	4	2	4	4	3	2	4	4	4	4	4	4	4	1	4	3	3	4	4	4
9	5	3	3	3	4	3	2	2	4	1	3	3	3	3	4	3	1	3	5	4	4	4
10	5	3	3	2	1	3	3	3	3	1	3	3	3	3	3	3	1	3	5	4	4	1
11	3	3	3	3	3	3	3	3	2	4	3	3	3	3	3	3	3	3	3	1	3	3
12	3	3	3	3	3	2	3	3	3	3	2	3	3	3	3	3	3	3	3	2	3	3
13	3	2	2	3	3	3	3	3	3	3	2	3	2	3	3	3	3	3	3	3	3	3
14	3	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
15	3	4	6	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	2	1	3	1	4	3	4
16	2	1	2	1	2	1	1	2	1	3	1	5	2	1	2	1	5	1	2	1	4	2
17	1	2	4	3	1	3	4	4	3	2	3	5	4	2	2	3	5	3	2	2	3	2
18	2	1	3	3	2	3	3	2	4	3	3	4	3	4	2	1	4	2	3	1	2	2
19	1	2	3	3	1	3	3	3	3	3	3	4	3	1	3	3	4	1	3	3	3	3
20	4	3	3	3	2	3	3	3	3	3	3	4	3	3	3	4	4	1	3	1	3	3
21	1	2	4	3	2	3	2	4	1	3	4	5	1	1	3	2	5	1	1	1	3	3
22	1	2	2	1	2	2	3	3	1	3	3	5	2	1	3	3	5	1	1	2	4	2
23	1	2	3	3	2	3	4	4	3	3	4	5	3	2	2	3	5	3	2	2	3	3
24	1	2	3	3	3	3	3	2	2	3	3	4	3	2	2	3	4	3	2	2	2	3
25	3	2	3	3	3	2	2	3	3	3	3	4	3	2	3	3	4	3	3	2	3	4
26	4	3	4	4	4	4	1	4	4	4	4	5	4	1	4	4	5	1	4	4	4	1
27	2	2	3	3	3	3	3	2	4	3	3	4	3	2	3	1	4	2	2	3	2	2
28	2	3	3	3	1	3	2	3	3	3	3	4	3	2	3	3	4	3	1	2	3	3
29	2	2	2	2	2	2	1	2	1	1	2	5	2	1	1	2	1	4	3	1	3	3
30	3	2	3	1	3	2	2	3	1	3	3	4	2	3	3	3	1	3	3	2	2	3
31	3	2	2	3	3	2	3	2	3	3	3	4	2	3	3	3	3	2	3	3	2	3
32	3	3	3	3	3	4	3	3	3	3	4	3	3	3	3	3	3	3	3	3	3	3
33	2	3	3	3	1	2	3	2	2	5	2	2	3	3	3	3	2	2	2	2	3	3
34	1	1	3	2	2	3	4	1	3	3	3	4	3	2	2	2	2	1	1	2	2	3

Үндсэн асуулгын хариултууд (Үргэлжлэл)

Асуулт	Архангай	Баян-Өлгий	Баянхонгор	Булган	Говь-Алтай	Говьсүмбэр	Дархан-Уул	Дорноговь	Дорнод	Дундговь	Завхан	Орхон	Өвөрхангай	Өмнөговь	Сүхбаатар	Сэлэнгэ	Төв	Увс	Улаанбаатар	Ховд	Хөвсгөл	Хэнтий
35	5	1	1	5	2	2	4	2	4	4	2	4	1	3	1	2	1	4	2	2	2	4
36	4	2	2	1	3	2	3	2	3	3	2	1	2	3	2	2	2	2	2	2	2	3
37	4	4	3	1	4	3	5	4	4	4	3	4	3	4	3	4	2	3	4	1	3	4
38	3	4	4	4	5	3	5	5	1	4	3	6	4	4	4	1	5	5	1	4	4	1
39	1	2	1	1	1	4	3	2	6	1	4	1	2	3	4	1	1	4	1	5	4	6
40	2	2	5	2	1	5	2	3	3	4	1	5	2	2	5	2	5	1	2	3	3	4
41	1	3	4	1	1	4	2	4	2	2	1	4	2	2	4	2	4	2	2	2	2	4
42	6	4	6	4	1	6	4	6	5	5	1	6	2	2	6	4	6	1	1	5	4	6
43	2	3	1	2	3	2	3	3	2	3	1	2	2	4	2	4	1	2	2	1	2	3
44	2	2	3	2	3	3	3	2	3	3	1	2	4	3	3	2	2	2	2	2	2	5
45	3	3	5	2	3	1	4	1	1	4	2	1	1	3	1	1	3	1	1	1	2	4
46	6	2	2	3	2	2	2	2	6	6	2	2	2	2	2	2	2	2	2	2	3	2
47	4	3	3	2	3	3	3	3	2	3	2	3	2	3	1	1	3	3	2	3	3	3
48	2	2	2	3	3	3	2	2	2	4	1	2	2	2	2	1	3	2	2	3	2	3
49	2	2	2	2	2	2	2	2	2	2	1	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
50	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2	2
51	2	3	1	1	3	2	1	1	1	3	3	1	1	3	3	1	1	4	3	1	1	3
52	3	2	3	1	3	4	3	3	1	3	2	4	3	3	3	4	1	2	4	1	3	3
53	1	2	1	1	1	4	2	1	1	1	1	1	1	2	1	1	1	2	1	1	1	1
54	3	3	3	4	3	3	3	3	3	3	4	3	3	3	3	1	3	3	2	3	3	3
55	1	3	3	2	3	1	2	1	1	3	3	3	3	3	3	1	3	3	3	1	3	1
56	3	3	3	3	3	2	3	3	1	3	3	3	3	3	3	3	3	3	4	3	3	3
57	2	3	3	2	2	1	2	1	3	3	2	2	3	3	2	1	2	3	2	1	3	3
58	4	3	3	4	2	1	1	1	4	2	2	1	3	2	1	3	2	1	2	2	1	3
59	1	1	1	2	1	1	1	1	1	2	2	1	1	1	1	3	1	1	3	2	1	1
60	2	3	2	2	3	3	3	2	2	4	2	5	3	2	3	1	2	4	1	3	2	3

## 6.5. Судлаачид

### АХЛАХ СУДЛААЧДЫН ЖАГСААЛТ

Нэр	Байгууллага, албан тушаал	Хариуцсан аймаг
М.Ариунтунгалаг	Хараат бус судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал	Завхан, Орхон, Өвөрхангай, Баянхонгор, Сүхбаатар, Говьсүмбэр
Д.Цэрэнжав	Ил тод байдал сангийн гүйцэтгэх захирал	Дархан, Хэнтий, Баян-Өлгий, Говь-Алтай, Өмнөговь, Дундговь
Б.Оюундарь	Зориг сангийн гүйцэтгэх захирал	Дорнод, Төв, Булган, Ховд, Хөвсгөл
М.Болормаа	Эмэгтэй удирдагч сангийн тэргүүн	Дорноговь, Увс, Улаанбаатар, Сэлэнгэ, Архангай

## ОРОН НУТГИЙН СУДЛААЧДЫН ЖАГСААЛТ

Аймаг	Нэр	Байгууллага, албан тушаал
Архангай	А.Алтанчимэг	ЛЭОС-ийн салбарын зохицуулагч, Мэргэжлийн сургалтын төвийн багш
Баян-Өлгий	А.Кеншилик	Аймгийн ҮЭ-үүдийн холбооны дарга
Баянхонгор	Б.Хандармаа	Баянхонгор аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимийн менежер
Булган	Д.Чимгээ	Булган аймгийн ЛЭОС-ын салбарын зохицуулагч
Говь-Алтай	Ч.Цэцэгмаа	Аймгийн Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөний зохицуулагч
Говьсүмбэр	Б.Шүрэнчимэг	Чойр-Хөгжил ТББ-ийн зохицуулагч
Дархан-Уул	Г.Соёлмаа	Аймгийн Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүд хөдөлгөөний зохицуулагч
Дорноговь	Н.Энхсүрэн	Аймгийн Гэр бүл аз жаргал төв ТББ-ын зохион байгуулагч
Дорнод	Ц.Түмэн	Дорнын цацал ХХК-ын захирал, сэтгүүлч
Дундговь	Д.Эрдэнэбилэг	Аймгийн Хөдөөгийн эмэгтэйчүүдийг дэмжих сангийн тэргүүн
Завхан	М.Дуламжав Б.Цэрэндулам	Эмэгтэйчүүдийн Төрийн бус байгууллагуудын сүлжээний зохицуулагч
Орхон	Б.Батжаргал	Оюунлаг нийгэмлэг Төрийн бус байгууллагын судлаач
Өвөрхангай	Т.Чулуунцэцэг	Орон нутгийн санаачлага Төрийн бус байгууллагын зохицуулагч
Өмнөговь	С.Энэбиш	Аймгийн ИНБ-ын сүлжээний зохицуулагч
Сүхбаатар	Н. Наранчимэг	Тасралтгүй алхам Төрийн бус байгууллагын тэргүүн
Сэлэнгэ	Б.Тамир	Аймгийн Эмэгтэй удирдагч сангийн ажилтан
Төв	Э.Ундрах	"Дэм төв" ТББ-ын захирал
Увс	Тогтох	"Сайн тус" ТББ-ын тэргүүн
Улаанбаатар	Б.Бүрэнжаргал	"Эмэгтэй удирдагч" сангийн сайн дурын ажилтан, судлаач
Ховд	Д.Баярмаа	"Ховд-Эрдэм" дээд сургуулийн сургалтын албаны ажилтан
Хөвсгөл	Б.Түмэндэмбэрэл	Хувь хүн
Хэнтий	З.Бат-Эрдэнэ	Хэнтий аймгийн ИНБ-уудын сүлжээний зохицуулагч

